

**“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН 2016 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

*/Хугацаа: 2016 оны 1 дүгээр сарын 01-нээс
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/*

Улаанбаатар хот
2016 он

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Оршил

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь 2016 оны үйл ажиллагаандаа Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 02/33 дугаар тогтоолоор батлагдсан компанийн Бизнес төлөвлөгөө, Гүйцэтгэх захирлын 2016 оны 04/04 дугаар тушаалаар батлагдсан компанийн 2016 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг тус тус удирдлага болгон ажиллалаа.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 8 удаа хуралдаж, Гүйцэтгэх захирлын орлогч, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, Дотоод хяналтын ажилтныг томилох, компанийн дүрмийн сангийн болон алдагдлаас хамгаалах сангийн мөнгөн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох, компанийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх байгууллагыг сонгох, давхар даатгалын гэрээ байгуулахыг зөвшөөрөх, 2016 оны санхүүгийн болон худалдан авалтын ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах зэрэг асуудлаар 15 тогтоол гарган тэдгээрийг хэрэгжүүлэн ажилласан.

1.2. Бүтэц, зохион байгуулалтын талаар

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх захирлын орлогч, Ерөнхий хуульч, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, Дотоод хяналтын ажилтан зэрэг удирдах бүрэлдэхүүн, Андеррайтингийн газар, Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар, Бизнес хөгжил, төслийн газар, Санхүү, удирдлагын газар гэсэн 4 нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Андеррайтингийн газар:

1. Газрын дарга
2. Даатгалын шинжээч-2
3. Андеррайтер /МИД хариуцсан/
4. Андеррайтер /Газар тариалан хариуцсан/
5. Андеррайтер /Бусад бүтээгдэхүүн хариуцсан/
6. Орон нутаг хариуцсан ажилтан
7. Мэдээлэл технологийн ажилтан

Бизнес хөгжил, төслийн газар:

1. Газрын дарга
2. Шинэ бүтээгдэхүүн хариуцсан ажилтан-2
3. Төслийн менежер
4. Эрсдэлийн шинжээч-2
5. Маркетингийн менежер
6. Гадаад хамтын ажиллагааны ажилтан

Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар:

1. Газрын дарга
2. Нөхөн төлбөрийн менежер
3. Хөрөнгө оруулалтын шинжээч
4. Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ажилтан

Санхүү, удирдлагын газар:

1. Санхүү, удирдлагын газрын дарга
2. Нягтлан бодогч
3. Захиргаа, олон нийтийн асуудал хариуцсан ажилтан
4. Жолооч-2

ХОЁР. ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. МИД-ын үйл ажиллагааг сайжруулах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

Оролцогч даатгагч нартай "Алдагдлыг зогсоох давхар даатгалын гэрээ"-г байгуулах:

Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газраас 2015 оны жилийн эцсийн мал тооллогын тоо, мэдээллийг авч холбогдох тооцоололд ашигласан ба 2015 оны эцсээр 153,085 малчин өрх, 216,734 малтай өрх, 56.0 сая мал тоологдсон байна.

Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл бүхий бүх даатгалын компаниудад 2016 онд хамтарч ажиллах талаар албан захиа хүргүүлснээс "Монгол Даатгал" ХХК, "МИГ Даатгал" ХХК, "Монре Даатгал" ХХК, "Бодь Даатгал" ХХК, "Практикал Даатгал" ХХК, "Тэнгэр Даатгал" ХХК-иуд үргэлжлүүлэн, "Ард Даатгал" ХХК, "Хаан Даатгал" ХХК-иуд шинээр 2016 оны борлуулалтын улиралд оролцохоор хүсэлт ирүүлсэн. Оролцох даатгалын компаниудаас бизнес төлөвлөгөөг хүлээн авсан ба 2016 оны борлуулалтын улиралд 8 даатгалын компани орон нутгийн 124 салбараараа дамжуулан МИД-ын борлуулалтыг хийв.

2016 оны борлуулалтын улиралд МИД-ыг борлуулан оролцохоор болсон 8 даатгалын компанитай "Алдагдлыг зогсоох давхар даатгалын гэрээ" байгуулан ажиллалаа. Эдгээр даатгалын компаниудын өгсөн 2016 оны борлуулалтын төлөвлөгөөгөөр нийт 31.4 тэрбум төгрөгийн үнэлгээтэйгээр 1.4 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлэхээр тусгасан.

"Алдагдлыг зогсоох давхар даатгалын гэрээ"-ний дагуу нийт 119.8 сая төгрөгийн давхар даатгалын хураамжийн урьдчилгааг 8 даатгалын компаниас төвлөрүүллээ.

МИД-ын борлуулалтыг хийх бэлтгэл ажлын хүрээнд:

Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газраас 2015 оны жилийн эцсийн малын тоо, малын дундаж үнэлгээг авч, 2016 оны борлуулалтанд хэрэглэх нэгж малын дундаж үнэлгээг 21 аймаг, 330 сум, Улаанбаатар хотоор боловсрууллаа.

2015 оны борлуулалтын улиралд ашиглахаар 44,000 ширхэг МИД-ын баталгааг "Мөнхийн үсэг" ХХК-д хэвлүүлсэн бөгөөд нэмж 9,300 ширхэг баталгааг хэвлүүлж, даатгалын компаниудад хуваарилан хүргүүлсэн.

Малын тоо, малтай болон малчин өрхийн тоо, малын үнэ, даатгалын компанийн салбар нэгжийн тоо, аймгуудын мэдээлэл зэрэг шаардлагатай тоон мэдээллүүдийг бэлтгэж, зохих загварын дагуу программд орууллаа.

Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулсан "Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ"-нд орон нутагт МИД-ын борлуулалтыг дэмжин ажиллах талаар тусган хэрэгжүүлдэг ба сумын Засаг дарга сумын Мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтэнтэй үр дүнгийн гэрээ байгуулан дүгнэн ажиллав. Энэхүү үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах, МИД-ын борлуулалтыг идэвхижүүлэн ажиллахыг үүрэг болгосон чиглэл бүхий албан бичгийн төслийг боловсруулж

Сангийн сайд болон Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар баталгаажуулан аймгийн Засаг дарга нарт хүргүүлэв.

МИД-ын сургагч багш бэлтгэх сургалтыг 2016 оны 2 дугаар сарын 29-ны өдөр “Ард даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Хаан даатгал” ХХК-иудад зохион байгууллаа. Даатгалын компаниудын МИД хариуцсан ажилтнуудын сургалтыг “Тэнгэр даатгал” ХХК-ийн байранд 3 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулав. Даатгалын төлөөлөгчдийг сургах сургалтын материалуудыг бэлтгэн Монголын даатгагчдын холбоонд хүргүүллээ.

Даатгалын төлөөлөгч сонгон шалгаруулах, эрх олгож гэрчилгээжүүлэх сургалтыг 3 дугаар сарын 10-ны өдрөөс 4 дүгээр сарын 03-ны өдрийн хооронд нийт 21 аймаг, Улаанбаатар хотод Санхүүгийн зохицуулах хороо, Даатгагчдын холбоо, даатгалын компаниуд хамтран зохион байгуулсан. Мөн 3 дугаар сарын 17-ны өдрөөс 21-ний өдрүүдэд Өвөрхангай, Архангай аймгуудад, 25-ны өдрөөс 28-ны өдрүүдэд Сүхбаатар, Хэнтий аймгуудад тус тус МИД-ын тухай сургалт хийсэн.

Сургалтаар МИД-ын тухай ойлголтууд, даатгалын төлөөлөгчийн баримтлах дүрмүүд, МИД төслийн хэрэгжилтийн үр дүн, МИД-ын талаар жишээ бодлого, МИД-ын хүрээнд байнга тохиолддог хүндрэлтэй асуудлууд, 2016 онд хийгдэх үйл ажиллагааны талаар танилцууллаа.

Сургалтанд оролцогчид МИД-ын болон ердийн даатгалын сургалтанд сууж, нэгдсэн шалгалт өгсөн бөгөөд нийт 21 аймаг, Улаанбаатар хотын 2,086 төлөөлөгч МИД-ыг борлуулах эрхтэй болж, борлуулалт хийж байна.

МИД-ын борлуулалтыг арилжааны банкаар дамжуулан хийх ажлын хүрээнд:

ХААН, Төрийн банкуудтай МИД-ыг зуучлан борлуулах ажлын хүрээнд "МИД-ын зуучлагчаар ажиллах журам"-ыг оролцогч талуудаас санал авсны үндсэн дээр 2016 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр шинэчлэн батлав. ХААН, Төрийн банкны салбар нэгжүүдэд МИД-ын зуучлалын талаарх сурталчилгааны зурагт хуудасны загварыг зуучлагч 2 банкнаас зөвшөөрсөн стандартаар гарган хэвлүүлж хүргүүлсэн. Зуучлагч банкаар борлуулах баталгааны маягтын загвар, гэрээний загвар зэрэг мэдээллүүдийг бэлтгэж программд орууллаа.

Төрийн банкны Мэдээллийн аюулгүй байдлын хэлтсээс МИД-ын программд хэрэглэгчийн нууц үг нууцлал өндөртэй байх, нууц үгийг 5-аас илүү хийвэл идэвхигүй болгох, хуучин хэрэглэгчийг идэвхигүй болгох горимтой болгох, борлуулалтын хайлтын талбар нэмэх зэрэг өөрчлөлтүүдийг хийлгүүлэв.

Сар бүрийн борлуулалтын тооцоо нийлэлтийг дараа сарын 5-ны өдрийн дотор нийлж, зуучлагч банк болон даатгалын компани хооронд давхардсан борлуулалтыг засуулж ажиллалаа. 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 8 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд нийт 80 борлуулалт давхардсан байсан ба тухай бүрийг нь засуулсан.

Төрийн банкны 21 аймгийн салбарын захирлуудад МИД-ын сургалтыг хийсэн бөгөөд уг сургалтаар МИД-ын үндсэн ойлголтууд болон зуучлалын талаар анхаарвал зохих асуудлаар ярилцаж ойлголтыг өглөө. Мөн зуучлагч банкны холбогдох мэргэжилтнүүдэд нөхөн төлбөр олгох зарчим, дарааллын талаар сургалт хийв.

ХААН банкны Даатгалын зуучлалын албаны ажилтнууд болон Төрийн банкны Даатгалын хэлтсийн ажилтнуудад МИД-ын эрсдэлийн үнэлгээний программ хангамжийн сургалтыг хийсэн ба хоёр банкны хувьд өөрийн орон нутаг дахь салбарууддаа банкны дотоод сүлжээгээ ашиглан программ хангамжийн сургалтыг хийж дууссан байна.

Мөн ХААН, Төрийн банкны төвийн салбарын ажилтнуудад болон оролцогч 8 даатгалын компанийн шинэ ажилтнуудад МИД-ын программ хангамжийн сургалтыг хийлээ.

МИД-ыг сурталчлан таниулах ажлын хүрээнд:

2015 онд малаа даатгуулсан малчдад хүргэх цаг тооны бичгийн эхийг бэлтгэн 15,000 ширхэгийг хэвлүүлж, даатгалын компани, төлөөлөгчдөөр дамжуулан 10,317 малчин өрхөд хүргүүлээ.

МҮОНТ-ээр “Үндэсний баялаг” нэвтрүүлэг 20 минутаар 2 удаа, Малчин ТВ-ээр “Мэдээний тодруулга” 3-5 минут, “Малчны хотонд” 20-25 минутын нэвтрүүлэг, “2000 секунд” зар сурталчилгаа, цаг агаарын нэвтрүүлгээр зурагт хуудсыг байршуулах сурталчилгааг 1 сарын турш тус тус нэвтрүүлсэн.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК болон МИД төслийн зүгээс хамтран гаргасан “Даатгал” сонины эхийг бэлтгэж, нийт 40,000 ширхэг хэвлэн малчид, даатгалын төлөөлөгч нарт хүргүүлсэн.

МИД-ын борлуулалтын ажлын хүрээнд:

МИД-ын 2016 оны борлуулалтын мэдээг 7 хоног тутам даатгалын компани, түүний салбар нэгж болон зуучлагч, холбогдох талуудад хүргүүлж ажилласан.

Даатгалд хамрагдах 9807-0770 утсаар МИД-д хамрагдах хүсэлтэй малчдаас дуудлага, мессежийг байнга авч, даатгалын компанийн орон нутгийн салбаруудаар дамжуулан даатгалын төлөөлөгчдөд мэдээлж байсан.

2016 оны МИД-ын программ хангамжийг бэлтгэх, шинэчлэл хийж сайжруулах тал дээр шаардлагатай мэдээллээр хангаж ажиллав.

Даатгалын төлөөлөгчдийн ажлын үйл явцтай танилцаж, борлуулалтыг эрчимжүүлэх зорилгоор даатгалын компанийн салбарын ажилчидтай утсаар холбогдож, заавар зөвлөгөө өгч ажилласан.

МИД-ын 2016 оны борлуулалтын хугацаанд 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд хийсэн борлуулалтын дүнгээр 8 даатгалын компанийн төлөөлөгчдийн дунд явуулсан “Манлай даатгалын төлөөлөгч” болон аймгийн “Тэргүүний даатгалын төлөөлөгч” шалгаруулах ажлыг амжилттай зохион байгууллаа. 18 аймаг тус бүрт нэг нэг “Тэргүүний даатгалын төлөөлөгч”, мөн улсын хэмжээнд нэг “Манлай даатгалын төлөөлөгч”-ийг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан.

Мөн МИД-ын борлуулалтын хугацааг сунгасантай холбоотойгоор 7 дугаар сарын 01-ны өдрөөс 31-ний өдрийн хооронд хамгийн их борлуулалт хийсэн даатгалын төлөөлөгчийг шалгаруулж “Саятан даатгалын төлөөлөгч” өргөмжлөл олгохоор болсон. Уг шалгаруулалтанд Увс аймгийн “Бодь даатгал” ХХК-ийн төлөөлөгч Д.Энхтайван нийт 65 борлуулалт, 4,903,415.00 төгрөгийн хураамж

төвлөрүүлснээр шалгарав. Дээрх 65 борлуулалтын баталгааны маягтыг нэг бүрчлэн шалгасан ба алдаа засвар байхгүй байсан болно.

МИД-ын борлуулалт 2016 онд **18,738 /арван найман мянга долоон зуун гучин найман/** малчин өрхийг даатгалд хамруулж, **1,774,078,280.87 /нэг тэрбум долоон зуун далан дөрвөн сая далан найман мянга хоёр зуун наян төгрөг наян долоон мөнгө/** төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлсэн байна. Энэ нь төлөвлөгөөний биелэлт малчин өрхийн тоогоор **104.4** хувь, хураамжийн орлого **104.3** хувьд хүрч нийт дүнгээр төлөвлөгөө биелсэн үзүүлэлттэй байна. /Тоогоо сайн хянах/

2.2. МИД-ын олон улсын давхар даатгалын гэрээ байгуулах чиглэлээр:

Оролцогч даатгалын компаниудын ирүүлсэн борлуулалтын төлөвлөгөөний дагуу 2016 оны МИД-ын нийт хураамжийн хэмжээг 2.07 тэрбум төгрөг буюу 1.03 сая (1\$=2000₮) ам.долларт хүрнэ гэж урьдчилан тооцоолсон. Энэхүү тооцооллоор малын даатгалын нийт үнэлгээ нь 46.17 тэрбум төгрөг буюу 23.08 сая ам.доллартай тэнцүү байна гэж үзэж, МИД-ын хамтран хариуцах дунд түвшний эрсдэлийг нийт хураамжийн 55 хувь давсан 135 хувь болон нийт хураамжийн 60 хувь давсан 130 хувь дээр үнийн санал авч давхар даатгуулах нь зүйтэй гэж үзсэн.

Олон улсын давхар даатгагчид болох “Qatar Re”, “Swiss Re”, “SCOR” зэрэг давхар даатгалын компаниуд руу албан захидал, танилцуулга, урьдчилсан тооцооллыг бэлтгэн явуулсан ба хамгийн бага үнийн санал ирүүлсэн “SCOR” компанийг тэргүүлэгч давхар даатгагч /60%/ -аар сонгон “Qatar Re” компанийг дагалдуулан /40%/ гэрээг байгуулсан. 2017 оны МИД-ын Алдагдал зогсоох олон улсын гэрээг нийт хураамжийн 60 хувь давсан 130 хувьтай тэнцүү эрсдэлийн хэмжээгээр байгуулсан ба гэрээний нөхцөлийн дагуу бодит нийт хураамжийн 16.9 хувь болох 122,440.50 ам.долларыг олон улсын давхар даатгагч нарт шилжүүлээд байна.

МИД-ын дээд түвшний эрсдэлийг нийт даатгалын үнэлгээний 0.3 хувь давсан 2.97 хувь болон 0.2 хувь давсан 2.97 хувь хүртэлх хэмжээгээр давхар даатгалд хамруулах үнийн санал авахаар тооцоолж “SCOR”, “Qatar Re”, “Swiss Re”, “Paris Liberty”, “Canopus Asia” зэрэг олон улсын давхар даатгагчдад үнийн санал авах албан захидал, танилцуулга, урьдчилсан тооцооллыг бэлтгэн явуулсан. Ирүүлсэн үнийн саналуудаас цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Swiss Re” компанийг нийт үнэлгээний 0.3 хувь давсан 2.97 хувьтай тэнцүү хэмжээний эрсдэлийг давхар даатгуулахаар гэрээг байгуулан давхар даатгалын хураамж болох нийт үнэлгээний 0.312 хувь /49,491.35 ам.доллар/-ыг шилжүүлсэн.

МИД-ын дунд түвшний давхар даатгалын хураамжийн орлого 608.7 сая төгрөг, дээд түвшний давхар даатгалын хураамжийн орлого 400.0 сая төгрөг, газар тариалангийн давхар даатгалын хураамжийн орлого 13.0 сая төгрөг, нийт 1,021.7 сая төгрөгийн орлого бүрдүүлээ.

2.3. Газар тариалангийн даатгалын олон улсын давхар даатгалын гэрээ байгуулах чиглэлээр:

“SCOR” олон улсын давхар даатгалын компани руу даатгуулагч “Өгөөж мандал уул” ХХК-тай байгуулсан гэрээ болон талбай дээрх хяналт шалгалтын тайланг бэлтгэн явуулсан ба тус компанитай “Хувь оролцооны давхар даатгалын

гэрээ"-г 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр байгуулж 2 тал гарын үсэг зурж гэрээний төлбөр болох 3,872.65 ам.долларыг шилжүүлсэн. Мөн түүнчлэн компанийн зүгээс газар тариалангын даатгалын бүтээгдэхүүний нөөцийг 2,054,871.90 төгрөгөөр бүрдүүлсэн.

2.4. МИД-ын борлуулалтын бүртгэл, хаалтын ажлын хүрээнд:

Борлуулалтын бүртгэл, хаалтын ажлын удирдамж боловсруулан оролцогч даатгагч, түүний орон нутгийн салбаруудад хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллалаа.

МИД-д оролцогч даатгалын компани хооронд болон зуучлагч банк хооронд давхардсан борлуулалтыг тухай бүрт нь шүүж даатгалын компанийн орон нутгийн салбаруудтай холбогдон засаж ажиллалаа. Мөн орон нутагт зуучлагч банкттай холбоотой хэд хэдэн асуудал гарсныг зуучлагч банкны төв хэлтэст мэдэгдэж залруулсан.

МИД-ын программ хангамжийн бүртгэлээс илэрсэн алдаатай борлуулалт, зөрчлүүдийг дор бүр нь илрүүлэн, холбогдох ажилтанд нь чиглэл өгч залруулга засвар хийлгэлээ.

Нийт оролцогч даатгагч, зуучлагч банкуудын борлуулалтыг дүгнэн нэгтгэх, давхар даатгалын хураамж, хамтын эрсдэлийн санг бүрдүүлэн ажилласан.

МИД-ын 2016 оны борлуулалтын тайланг нэгтгэн оролцогч даатгалын компаниудтай үр дүнгийн гэрээ байгуулж баталгаажууллаа.

МИД-ын 2016 оны борлуулалтанд оролцсон даатгалын компаниудаас хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө болох 798,335,226.00 /долоон зуун ерэн найман сая гурван зуун гучин таван мянга хоёр зуун хорин зургаан/ төгрөгийг бүрдүүлж зохих журмын дагуу ХААН, Хас, Голомт, Төрийн банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулсан. Мөн дээрх даатгалын компаниудаас давхар даатгалын хураамжийн үлдэгдэл 471,581,279.51 /дөрвөн зуун далан нэгэн сая таван зуун наян нэгэн мянга хоёр зуун далан есөн төгрөг тавин нэгэн мөнгө/ төгрөгийг төвлөрүүллээ. 2015 оны Хамтын эрсдэлийн сангийн үлдэгдэл хөрөнгө болох 215,767,224.36 /хоёр зуун арван таван сая долоон зуун жаран долоон мянга хоёр зуун хорин дөрвөн төгрөг гучин зургаан мөнгө/ төгрөгийг оролцогч 6 даатгалын компанид хуваарилан олгосон.

МИД-ын зуучлагчаар ажилласан 2 банкны борлуулалтын багцыг даатгалын компаниудад хуваарилах тооцооллыг гарган банкуудад хүргүүлсэн. Эдгээр 2 банкнаас даатгалын компаниудад шилжүүлэг хийн гэрээний дагуу даатгалын компаниуд эргүүлэн даатгалын шимтгэл /комисс/-ийг 2 банкинд тушаасан болно.

Зуучлагч банкуудаас ирэх жилийн борлуулалтын ерөнхий төлөвлөгөөг авч бизнес төлөвлөгөөндөө тусгалаа. Банкууд борлуулалтаа 5 хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна. Мөн 2 банкнаас программд оруулах өөрчлөлт, нэмэлт санал хүсэлтийг авч программд оруулахаар боллоо.

ГУРАВ. БИЗНЕСИЙН ХӨГЖИЛ, ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Даатгалын бүтээгдэхүүний загварыг гаргах, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж турших ажлыг хийж хэрэгжүүлэх чиглэлээр:

Улаан буудайн даатгалын шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх чиглэлээр Хүнс, хөдөө аж ахуйн яам болон “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-тай хамтран ажиллаж тухайн бүтээгдэхүүнийг боловсруулахад шаардлагатай тоон мэдээллийг цуглуулж бүтээгдэхүүний загварт ашиглалаа.

Улаан буудайн даатгалын бүтээгдэхүүний загварыг боловсруулахдаа олон улсын жишигт нийцсэн уламжлалт ургац алдалтын хэмжээгээр нөхөн төлбөр олгох хэлбэртэй бүтээгдэхүүнийг сонгосон. Тус улаан буудайн даатгалын бүтээгдэхүүний танилцуулгыг англи, монгол хэл дээр бэлтгэж, олон улсын зөвлөх Олена Сосенкод илгээн санал авсан бөгөөд “SCOR” олон улсын давхар даатгалын компанид хүргүүлж давхар даатгалд хамруулахаар болсон.

Улаан буудайн даатгалын бүтээгдэхүүнийг танилцуулах, оролцогч талуудтай мэдлэг, мэдээлэл, туршлага солилцох зорилгоор 3 дугаар сарын 10-ны өдөр зөвлөлдөх уулзалт зохион байгууллаа. Зөвлөлдөх уулзалтад газар тариалан эрхлэгч аж ахуй нэгжүүдийн төлөөлөл, Газар тариалангийн холбоод, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Ус цаг уур, орчны шинжилгээний газар, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, даатгалын компаниуд, банкны төлөөлөл оролцсон. Энэхүү зөвлөлдөх уулзалтаар Олон улсын зөвлөх Олена Сосенко илтгэл тавьж, бүтээгдэхүүнтэй холбоотой асуултуудад хариулт өглөө. Уулзалтаар оролцогч талууд улаан буудайн даатгалын бүтээгдэхүүний талаар нэгдсэн ойлголттой болж, газар тариалангийн салбарыг хамгаалалтад авах зайлшгүй шаардлагатай болсон өнөө үед цагаа олсон, ач холбогдолтой бүтээгдэхүүн байна гэж үзсэн бөгөөд дэмжихээ илэрхийлсэн юм.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн агрономчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллалаа. Сонгон шалгаруулалтын зарыг өдөр тутмын сонин, байгууллагын цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд тавьж зарлуулсан ба зарын дагуу нийт 9 хүн танилцуулгаа ирүүлснээс шаардлага хангасан 5 хүнийг ярилцлаганд оруулж С.Ариун-Эрдэнийг сонгон шалгаруулж агрономичоор томилон гэрээгээр ажиллуулж байна.

Андеррайтингийн журмыг орчуулан “Тариалан эрхлэлтийг дэмжих сан” болон агрономичоос шаардлагатай мэргэжлийн саналыг авч англи, монгол хэл дээр боловсруулан бэлэн болголоо. Андеррайтингийн журмыг гарын авлага болгож, хамтран ажиллаж буй ердийн даатгалын байгууллагуудад хүргүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хохирлын үнэлгээний заавар болон Нөхөн төлбөрийн журам зэргийг орчуулан газар тариалангийн андеррайтераар хянуулж зөвлөгөө авсан. Үүнээс хохирлын үнэлгээний зааврыг гарган агрономичийн санал, олон улсын шинжээч Олена Сосенкогоос зөвлөгөөг тусган бэлэн болголоо.

Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалын гэрээний төсөлд Санхүүгийн зохицуулах хорооноо болон бусад холбогдох байгууллагуудаас санал авч, гэрээний эцсийн хувилбарыг боловсруулсан.

Газар тариалангийн даатгал хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж болох орон зайг тодорхойлогч /GPS/, жин хэмжүүр, чийг хэмжигч зэргийн техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлж, дотоодод импортлон оруулж ирдэг компаниудаас үнийн санал танилцуулгыг авч нэгтгэн харьцуулалт хийн, шаардлагатай төхөөрөмжийг

худалдан авсан. Улаан буудай тариалсан талбайн соёлолтыг үзэх, даатгалын тохиолдол гарсан үед мөн эрсдэл тохиолдсон талбайд дээрх багаж төхөөрөмжөөр координат болон үр тарианы жин чийгшлийг хэмжихэд ашиглаж байна.

Улаан буудайн даатгалын туршилтын бүтээгдэхүүнийг борлуулах сумдыг эцэслэн тодорхойллоо. Аймаг сумдын газар зүйн байршил болон эрсдэлийн түвшинг харгалзан Сэлэнгэ, Төв, Булган аймгийн хураамжийн хувийн тооцоолол, холбогдох мэдээллийг ашиглан хэд хэдэн сумдыг сонгож, сонгосон сумдын мэдээллийг “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-д хүргүүлж, санал авч ажиллалаа. Дээрх мэдээллүүдэд үндэслэн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Ерөө, Зүүнбүрэн, Цагааннуур, Баруунбүрэн, Орхонтуул, Түшиг, Хүдэр, Төв аймгийн Цээл сумдад улаан буудайн даатгалын бүтээгдэхүүнийг туршилтын журмаар борлуулахаар болсон.

Газар тариалангийн даатгалын шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх ажлын хүрээнд “Тариалан эрхлэх сан”-тай хамтран ажилласнаар тариалангийн даатгалын бүтээгдэхүүн боловсруулах ажилд шаардлагатай мэдээллийг авч, хамтран ажиллав. Улаан буудайн даатгал хийгдэх туршилтын сумдаас газар тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж тус бүрийн сүүлийн 5 жилийн тариалалт, ургацын талаарх мэдээлэл авах албан захиаг бэлтгэн Сэлэнгэ, Төв аймгийн Засаг даргын тамгын газарт явуулж, мэдээллийг хүлээн авсан. Энэхүү мэдээлэл нь даатгуулахыг хүссэн тариалан эрхлэгчдийн өгсөн ургацын талаарх мэдээллийг баталгаажуулж, мэдээллийн сан бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах даатгалын компанийг сонгон шалгаруулах тухай урилга бэлтгэн, даатгалын нийт 15 компанид явууллаа. Үүнээс “Ард даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Мандал даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “МИГ даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Соёмбо даатгал” ХХК, “Хаан даатгал” ХХК-иуд оролцох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн ба эдгээр компаниудын удирдлагуудтай 2016 оны 3 дугаар сарын 25-ны өдөр уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтаар бүтээгдэхүүний талаар танилцуулга хийж, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-иас хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон оролцогч даатгалын компаниудад тавих шалгуур үзүүлэлтийг танилцуулав. Даатгалын компаниудад бизнес төлөвлөгөө хийх ажлын удирдамж болон холбогдох мэдээллийг бэлтгэн хүргүүлсэн.

Улаан буудайн даатгалд хамрагдах өргөдлийн маягтыг боловсруулж, зарим сумдын газар тариалан эрхлэгчдэд хүргүүлэв. Даатгалын гэрээг англи хэлнээс монгол хэл рүү орчуулж, гэрээний төслийг боловсрууллаа. Энэхүү гэрээг оролцох хүсэлтээ илэрхийлсэн даатгалын 9 компанид хүргүүлсэн.

“Ард даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Мандал даатгал” ХХК, “МИГ даатгал” ХХК-иуд бизнес төлөвлөгөө болон хамтран ажиллах саналаа ирүүлсэн ба 4 дүгээр сарын 07-ны өдөр эдгээр компаниудтай хамтран ажиллахаар шийдвэрлэсэн. “Улаан буудайн тариалангийн даатгалын тогтвортой байдлын гэрээ”-ний төслийг боловсруулж, 5 дугаар сарын 01-ний өдөр тус гэрээг дээрх даатгалын компаниудтай байгуулав. Энэхүү гэрээ нь улаан буудайн даатгалын бүтээгдэхүүн, түүнтэй холбоотой аливаа гэрээ, аргачлал, заавар журам, мэдээ, мэдээллийг зүй зохистой ашиглах болон “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-тай 3 жил тогтвортой ажиллах харилцааг зохицуулсан болно.

Улаан буудайн даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах эрх бүхий “Ард даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Мандал даатгал” ХХК, “МИГ даатгал” ХХК-иудын улаан буудайн даатгалын бүтээгдэхүүний зөвшөөрөл авах үйл ажиллагаанд туслах зорилгоор холбогдох гэрээ, заавар, мэдээллийг бэлтгэн хүргүүлэв.

Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас 4 дүгээр сарын 14-ний өдөр “Тариаланчдын улсын зөвлөгөөн”-ийг Дархан-Уул аймагт зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд Ус цаг уур, орчны шинжилгээний газар, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Дарханы Ургамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд, туршлагатай тэргүүний тариаланчид оролцож судалгаа шинжилгээний үр дүн, энэ жилийн тариалалттай холбоотой асуудлаар илтгэл тавьсан. Уг зөвлөгөөнд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Бизнес хөгжил, төслийн газрын дарга газар тариалангийн салбарт тохиолдож буй эрсдэл, нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалын бүтээгдэхүүний талаар танилцуулга илтгэл тавьсан. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн зүгээс Бизнес хөгжил, төслийн газар, Андеррайтингийн газрын дарга, холбогдох ажилтнууд компаниа төлөөлөн оролцож, тариалан эрхлэгчдэд улаан буудайн даатгалын шинэ бүтээгдэхүүнээ танилцуулж, сонирхсон хүмүүсийг өргөдлийн маягт, судалгааны хуудсан дээр ажиллуулж, дадлагажуулсан.

Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын холбогдох албан тушаалтнуудад 4 дүгээр сарын 20-ны өдөр улаан буудайн даатгалын бүтээгдэхүүний судалгаа, эрсдэлийн тооцоолол, андеррайтинг, борлуулалт, нөхөн төлбөр олголтын талаар танилцуулга мэдээлэл хийлээ.

Улаан буудайн даатгалын бүтээгдэхүүнийг туршилтын журмаар борлуулах болсон Цагааннуур сумын “Баянсэлэнгэ” ХХК, “Ургацын хишиг” ХХК, “Гацуурт” ХХК, “Номунхан” ХХК, Орхонтуул сумын Гантөмөр, Баруунбүрэн сумын “Бүрэн-Эрдэнэ Монос” ХХК, Түшиг сумын “Анхтамир” ХХК-иудын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, бүтээгдэхүүний талаар мэдээлэл өгөв.

Улаан буудайн даатгалд хамрагдах өргөдлийн маягтаа өгсөн газар тариалан эрхлэгч компаниудын улаан буудай тариалсан талбайг үзэж шалгах, соёололтын байдалтай танилцах зорилгоор 6 дугаар сарын 13-ны өдрөөс 20-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Хүдэр, Хушаат сумдууд, Төв аймгийн Цээл суманд ажилласан.

“Бодь даатгал” ХХК-д 6 дугаар сарын 24-ний өдөр Хушаат сумын “Өгөөж Мандал Уул” ХХК-ийн улаан буудай тариалсан 250 га талбайг даатгалд хамруулж, анхны гэрээг байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллалаа.

“SCOR” олон улсын давхар даатгалын компанид даатгуулагч “Өгөөж мандал уул” ХХК-тай байгуулсан гэрээ болон талбай дээрх хяналт шалгалтын тайланг бэлтгэн хүргүүллээ. Олон улсын давхар даатгалын компаниас хамтран ажиллах саналыг хүлээн авч “SCOR” олон улсын давхар даатгалын компанитай “Хувь оролцооны давхар даатгалын гэрээ”-г дагуу 9 дүгээр сарын 09-ний өдөр байгууллаа.

Газар тариалангийн индексжүүлсэн даатгалыг нэвтрүүлэх талаар:

2016 онд хэрэгжүүлсэн уламжлалт нэрлэсэн эрсдэлт улаанбуудайн даатгал нь зардал өндөртэй, тариаланчдын хувьд төлөх даатгалын хураамж нь өндөр байсан зэрэг шалтгааны улмаас 2017 оноос газар тариалангийн индексжүүлсэн даатгалыг “SCOR” олон улсын давхар даатгалын компаниас техникийн тусламж,

зөвлөгөө авч нэвтрүүлэхээр болсон бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлуудыг хийлээ.

- Цаг уур орчны шинжилгээний газрын холбогдох мэргэжилтэнтэй уулзаж, цаг уурын мэдээлэл хэрхэн гардаг болон Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа цаг уурын станцуудын талаарх мэдээллийг авлаа.
- Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын холбогдох мэргэжилтэнтэй уулзаж, газар тариалангийн эдэлбэр газрын мэдээлэл, цаг уурын станцуудын байршлын талаарх мэдээллийг авч, судалгаа хийлээ. Мөн цаашид газар тариалангийн талбайн кадастрын ажлын хүрээнд хамтарч ажиллахаар боллоо.
- Дээрх 2 уулзалтын үр дүн болон авсан материалуудад судалгаа хийж үзэхэд индексжүүлсэн даатгалын статистик мэдээлэл /цаг уурын мэдээлэл/-ийг хиймэл дагуулын мэдээллээс авахаар тогтлоо. Учир нь Монгол улсын цаг уурын станцын мэдээлэл нь олон улсын шаардлагыг хангаж чадахгүй буюу тариалангийн талбайгаас хол байна гэж үзсэн.
- “SCOR” олон улсын давхар даатгалын компаниас ирсэн газар тариалангийн индексжүүлсэн даатгалын талаарх мэдээлэлтэй танилцаж, цаашид бүтээгдэхүүний загварыг гаргах, төсвөө тодорхойлохоор боллоо.
- Газар тариалангийн үйл ажиллагаа явуулдаг нийт 16 аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт тариалалт болон ургацын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авах зорилготой албан захиаг явуулсан бөгөөд одоогоор нийт 13 аймгийн мэдээллийг авч нэгтгээд байна.

“Хөдөө аж ахуйн инновацийн нэгдэл” ТББ-тай хамтран 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдөр “Хөдөө аж ахуйн даатгалын бодлого, тогтолцооны шинэчлэл” хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэг нь хөдөө аж ахуйн салбарт учирч буй эрсдэл, түүнийг бууруулах арга зам, тус салбарын даатгалын өнөөгийн байдлын талаар хэлэлцэж цаашид хэрэгжүүлэх бодлогоо тодорхойлох, эрх зүйн орчинг сайжруулах, талуудын оролцоог идэвхижүүлэх, хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог шинэчлэх зорилготой зохион байгуулагдсан бөгөөд тус хэлэлцүүлэгт Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хөдөө аж ахуйн их сургууль, Монголын ХАА-н инновацийн нэгдэл /консорциум/, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК, даатгалын компаниудын төлөөлөл болон газар тариалан эрхлэгчдийн төлөөлөл болох нийт 50 гаруй хүмүүс оролцлоо. Хэлэлцүүлгээс гарсан үр дүнг бодлого боловсруулагчдад хүргэсэн.

3.2. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, шаардлагатай судалгаа хийх, сургалт зохион байгуулах чиглэлээр:

Дэлхийн банкны Ази номхон далайн бүс нутгийн санхүүгийн салбарыг хариуцсан ахлах мэргэжилтэн Уллэ 3 дугаар сарын 18-24-ний өдрүүдэд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн үйл ажиллагаатай танилцаж, экспортын даатгалын төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар судалгаа хийсэн. Энэ ажлын хүрээнд зөвлөх мэргэжилтэнтэй уулзах уулзалтыг зохион байгуулж, судалгааны ажилд шаардлагатай тоон мэдээлэл, холбогдох хууль, дүрэм, журмыг хүргүүлээ.

Хүнс, хөдөө аж ахуйн яам дээр хэрэгжиж байгаа “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн багийнхантай уулзалт зохион байгуулж цаашид хамтран ажиллах чиглэлийн талаар тохиролцоонд хүрсэн. ХБНГУ-ын “Тогтвортой хөдөө аж ахуй” төсөлтэй хамтран газар тариалангийн даатгалын бүтэц болон хууль эрх зүйн орчинг

бүрдүүлэх талаар хамтран ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд газар тариалангийн хохирол үнэлгээний зохистой бүтэц бүрдүүлэх талаар хамтран ажиллахаар тохиролцлоо.

Дэлхийн банк, Монгол Улсад экспортын даатгалын төсөл хэрэгжүүлэхэд макро, месо, микро эдийн засгийн үзүүлэлтүүд шаардлагатай байгаатай холбогдуулан дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Монгол Улсын даатгалын салбартай холбогдох хууль, дүрэм журмыг орчуулсан.
- Төслийн зорилтот бүлэг болох Жижиг дунд үйлдвэр болон холбогдох холбоодтой уулзалтуудыг зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд орчуулга хийсэн.
- “Экспортын даатгалын төсөл”-ийн үйл ажиллагааны зардлын судалгааг орчууллаа.
- Монгол Улс дахь экспортлогч болон бүтээгдэхүүнээ экспортлох хүсэлтэй аж ахуй нэгжүүд болох “Seaberry”, “National essentials & Lhamour 2016”, Монголын ноос ноолуурын холбоо, Монголын Үндэсний Худалдаа Аж үйлдвэрийн танхим, Экспортлогчдын зөвлөл, “Монгол Шевро” ХХК, “Хатан сүйх” ХХК зэрэг аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал болон тулгарч байгаа асуудлуудын талаар ярилцлаа.
- Монгол Улс дахь экспортлогч болон бүтээгдэхүүнээ экспортлох хүсэлтэй аж ахуй нэгжүүдтэй хийсэн уулзалтын тайланг бичиж орчуулсан.
- Экспортын төслийн танилцуулгыг аж ахуй нэгжүүд рүү илгээн, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциациас ирсэн төлөөлөгчдийг хүлээн авч 2016 оны 9 дүгээр сарын 13-16-ны өдрүүдэд Монгол Улс дахь экспортлогч болон бүтээгдэхүүнээ экспортлох хүсэлтэй аж ахуй нэгжүүдтэй уулзалт зохион байгуулсан. Энэхүү уулзалтанд Дэлхийн банкны төлөөлөгчид болон тус компанийн газрын дарга, төслийн менежер, нийт 12 аж ахуйн нэгж, 2 төрийн байгууллагын төлөөлөл оролцлоо.

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан “Экспортыг дэмжих төсөл”-ийн Санхүүжилтийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их хурал 2016 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр соёрхон баталсан. Уг санхүүжилтийн хэлэлцээрийг соёрхон баталсантай холбогдуулан Сангийн яам, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн хооронд байгуулах санхүүжилтийн дэд хэлэлцээрийн төсөлтэй танилцаад 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 03/211 тоот албан бичгээр Сангийн яаманд санал хүргүүлж, холбогдох мэргэжилтэн дарга нартай уулзаж гэрээг байгуулахаар тохиролцсон. Үүнтэй холбоотойгоор:

- Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй Экспортын даатгалын төслийг хэрэгжүүлэх гарын авлага буюу төслийг хэрэгжүүлэхэд мөрдлөг болгон ажиллах баримт бичгийг боловсруулахад оролцож, монгол хэл рүү хөрвүүлсэн.
- Төслийн хэрэгжилтийг хангах зорилгоор Экспортын даатгалын газрыг байгуулан, үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан тус газрын 2017 оны ажлын төлөвлөгөөг боловсруулсан.

- Дэлхийн банкны Ази номхон далайн бүс нутгийн санхүүгийн салбарыг хариуцсан Ахлах мэргэжилтэн Уллэгээр удирдуулсан баг, бүрэлдэхүүн 2016 оны 11 дүгээр сард хүрэлцэн ирж, Хөдөө аж ахуйн давхар даатгал компанийн Гүйцэтгэх захирал, Бизнес хөгжил, төслийн газрын дарга, төслийн менежер, хуульчтай төслийн хэрэгжилттэй холбоотой уулзалт хийсэн бөгөөд тус уулзалтуудын бэлтгэл ажлыг ханган, амжилттай зохион байгуулсан.
- Дэлхийн банкны Санхүүгийн мэргэжилтэн Арнаудтай төсөл хэрэгжүүлэх гарын авлага, худалдан авалтын төлөвлөгөөний талаар хэлэлцэж зөвлөлдсөн.
- Экспортын даатгалын бүтээгдэхүүний зах зээлийн судалгааг хийж Дэлхийн банкинд шаардлагатай мэдээллүүдийг тухай бүр боловсруулан гаргаж өгсөн.
- Төслийг хэрэгжүүлэхэд мөрдлөг болгон ашиглах, мэдээлэл мэдлэг эзэмших баримт бичгүүдтэй танилцаж, судалж байна.
- Олон улсын нэр хүнд бүхий экспортын чиглэлийн холбоо, нийгэмлэг, байгууллагад гишүүн байгууллагаар элсэх, олон жилийн туршлагатай мэргэжилтэн, зөвлөхүүдтэй хамтран ажиллах зэрэг ажлын хүрээнд холбогдох судалгааг хийж албан захидлыг хүргүүлж байна.
- Экспортын даатгалын төслийн үйл ажиллагааны зардлын судалгааг хийж эхний сар болон 18 сарын үйл ажиллагааны зардал, Экспортын даатгалын компанийн эхлэлтийн баланс болон үйл ажиллагааны зардлыг Монгол дахь даатгалын компаниудын үйл ажиллагааны зардалд үндэслэн 4, 5 жилээр боловсруулж гүйцэтгэх удирдлагад танилцуулан Дэлхийн банкинд хүргүүлсэн.
- Экспорт болон хөрөнгийн даатгалын чиглэлээрх олон улсын сургалт хөтөлбөрийн зардлыг тооцон гаргасан.
- “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ийг судалж боловсруулалт хийсэн.

Санхүүгийн зохицуулах хороо, Дэлхийн банктай хамтран зохион байгуулсан шат дараалсан мэдлэг олгох сургалтад 2016 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс 25-ны өдрийн хооронд Бизнес хөгжил, төслийн газар болон Андеррайтингийн газрын мэргэжилтнүүд хамрагдлаа.

Газар тариалан, хөдөө аж ахуйн чиглэлээр Монгол Улсад хэрэгжиж буй холбогдох төслүүдтэй хамтран ажиллах ажлын хүрээнд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн ажилтнуудын чадавхыг сайжруулах төслийн хүсэлтийг боловсруулан Азийн хөгжлийн банкинд хүргүүлсэн болно.

Монголын даатгагчдын холбооны захиалга, санхүүжилтээр даатгалын салбарын стратеги төлөвлөлтийн өргөтгөсөн хэлэлцүүлгийг зохион байгуулах ажлын хүрээнд Холбооны бүх гишүүн компаниуд болох Санхүүгийн зохицуулах хороо, Албан журмын даатгагчдын холбооны ажиллагсдыг хамруулсан “Nomadic School of Business”-тэй хамтран “Drawing your future vision of the insurance industry” сэдэвт сургалтад хамрагдан 4 дүгээр багт хуваарилагдаж ажиллан, зохион явуулсан тэмцээнд багаараа тэргүүн байр эзэллээ.

Гамшгийн даатгалын талаар судалгаа хийж танилцуулга бэлтгэн компанийнхаа ажилтнуудад танилцуулахаар бэлдээд байна.

Германы “Climate insurance fund”-д Монголын малчид болон тариаланчдын тоон мэдээ, дундаж орлого, ХААН банкаар зуучлан борлуулсан малын индексжүүлсэн даатгалын тухай мэдээллийг хүргүүлэв. 2016 онд ХААН банкаар 1828 малчин 162.6 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн ба МИД-д даатгуулдаг малчдын дийлэнх хувь нь 50-500 малтай малчин өрх байдаг байна. Мөн Монгол Улсын нийт малчдын 62.5 хувь нь 50-500 малтай малчин өрх эзэлж байна. Тэдгээр малчдын орлогын эх үүсвэр нь ноос, ноолуур, арьс шир, мах, сүү, цагаан идээнээс олох орлого бөгөөд жилд дунджаар 8.0 сая төгрөгийн орлоготой байна.

Тариаланчдын хувьд 2014 оны байдлаар газар тариалан эрхэлдэг нийт 33461 өрх, 1705 аж ахуйн нэгж байна. Манай улсын нийт өрхийн 3.5 хувь нь газар тариалан эрхэлж байна. 2014 оны байдлаар газар тариалан эрхэлдэг өрхийн сарын дундаж орлого 700.4 мянган төгрөг, аж ахуйн нэгжийн хувьд 1.4 сая төгрөгийн орлоготой байгаа ба өрх, аж ахуйн нэгжийн сарын хамгийн бага орлого 27.0 мянган төгрөгтэй тэнцүү байна. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос хүн амын амьжиргааны доод түвшинг тогтоодог бөгөөд дээрх тариалан эрхлэгч иргэдийн 7.0 хувь нь амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой байна.

Компанийн 2017 оны бизнес төлөвлөгөөг боловсруулахдаа санхүүгийн салбарын эрсдэлийн судалгаа, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа хууль эрх зүйн өнөөгийн орчин, тулгарч байгаа эрсдэлийн судалгаа, даатгалын зах зээлийн ерөнхий төлөв байдлын судалгаа, Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын талаар судалгаа, үр ашигтай эрсдэлийн удирдлагын цогц бодлогын судалгаа, хөдөө аж ахуйн салбар дахь даатгалын эрсдэлийн судалгаа, улс төр, эдийн засгийн эрсдэлийн шинжилгээ зэргийг хийж, үндэслэл болголоо.

Мөн Үндэсний статистикийн хороо, Монгол Банк, Сангийн яамны зүгээс гаргасан судалгаа тоймуудтай танилцан, Хөдөө аж ахуйн салбарт төр засгийн зүгээс гаргаж, хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээг судлан шинжилж, даатгалын мэдлэгийг олгох тал дээр түлхүү анхаарч, борлуулалтын шинэ суваг гаргах стратеги төлөвлөгөөнд тулгуурлан боловсрууллаа. Олон улсын валютын сангийн 2001 стандартыг үндэслэл болгон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулсан.

“Макс-Агро” ХХК-ийн 229 үнээ, 129 бяруу, 97 тугал, 1 бухыг давхар даатгах зорилгоор “Тэнгэр даатгал” ХХК-ийн борлуулалтын ерөнхий менежертэй хамтран фермийн үйл ажиллагааг газар дээр нь очиж, үзлэг хийлээ. Үзлэгээр фермийн орон байрны байдал, өвс тэжээл, үхрийн байдалтай танилцаж, асуулга судалгаа авсан. Эхний байдлаар даатгуулагчаас асуулга судалгааг авч, олон улсын давхар даатгалын компани руу үнийн санал авахаар явуулаад байна.

3.3. Олон улсын болон төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр:

Хөрөнгийн давхар даатгалын талаар судалгаа явуулах зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувьцаат компанийн хөрөнгийн болон бусад даатгалын тоон мэдээллийг боловсруулахаар Санхүүгийн зохицуулах хороонд албан тоот хүргүүлсэн бөгөөд холбогдох мэргэжилтэнүүдтэй уулзалт зохион

байгууллаа. Мэдээлэл цуглуулах үүднээс эдгээр байгууллагуудын санхүүгийн тайлан балансад шинжилгээ хийж, зарим хувьцаат компаниудын даатгалын талаарх мэдээллийг нэгтгэн боловсруулж ажиллалаа.

Мөн энэхүү арга хэмжээний хууль эрх зүйн баримт бичгийг боловсруулахаар Сангийн яамны Санхүү, даатгалын газрын мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулсан. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн тусгай зөвшөөрөлд зөвхөн мал, газар тариалангийн буюу хөдөө аж ахуйн даатгалын үйл ажиллагаа эрхлэхээр гэрчилгээнд тусгасан байдаг. Үүнтэй холбогдуулан гэрчилгээнд хөрөнгийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх нэмэлт заалт оруулсан тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит хувьцаат компанийн хөрөнгийг даатгах боломжтой болох юм.

Эрдэнэтийн Уулыг Баяжуулах үйлдвэр, Иргэний нисэхийн ерөнхий газар, “ТЭЦ III” ХК-ийн хөрөнгийн даатгалын талаар мэдээллийг холбогдох мэргэжилтнүүдээс авсан ба эдгээр мэдээлэл нь улсын нууцлалд хамаардаг тоног төхөөрөмжүүдтэй холбоотой тул “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн хувьд нууцын зэрэгт оруулсан болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ХК-ийн хөрөнгийн даатгал болон давхар даатгалын талаар “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн удирдлагуудад танилцуулга бэлтгэн хүргүүлж холбогдох үүрэг, чиглэл авч ажиллаж байна.

Дотоодын даатгагчдын эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгалын эрэлт хэрэгцээг судлахаар ердийн даатгалын 15 компанид албан тоот хүргүүлж хариу мэдээллийг авч хүснэгтлэн нэгтгэлээ.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Энхтайван 6 дугаар сарын 15-ны өдөр ОХУ-ын “Russian Re” давхар даатгалын төрийн өмчит компанитай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Тус санамж бичгээр хоёр компани харилцан ашигтай, тогтвортой ажиллах, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК давхар даатгалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэхэд туслалцаа үзүүлэх, цаашид ердийн даатгалын давхар даатгалын чиглэлээр хамтарч эрсдэл үүрэх бололцоо нээсэн болно.

Турк Улсаас Монгол Улсад суугаа элчин сайдын яамны дэд сайд ноён Давут Ихсан Изчитэй 2016 оны 5 дугаар сарын 20-ны өдөр уулзалт зохион байгуулж тус улсын хөдөө аж ахуйн даатгалын компанитай хамтран ажиллах, туршлага судлах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.

Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй төсөл”-ийн удирдагч Др.А.Катер, зөвлөх Б.Поешк нартай 6 дугаар сарын 17-ны өдөр уулзаж, Тариалангийн даатгалд хэрэгцээтэй байгаа асуудлын талаар ярилцаж, хуулийн төсөл, хохирол үнэлгээ, хураамжийн тооцоололд мэргэжлийн зөвлөгөө авч ажилласан.

Монгол Улсын Ерөнхий сайдын Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад хийсэн айлчлалын үеэр буюу 2015 оны 7 дугаар сарын 02-ны өдөр тус улсын “Lloyd’s” компанийн захирал Жон Фредерик Нельсон Ерөнхий сайдад бараалхсан. Тус уулзалтаар Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарт даатгалын чиглэлээр хамтын ажиллагаагаа өрнүүлэх талаар санал тавьсан бөгөөд энэ ажлын хүрээнд тус компанийн Сингапур дахь салбарын захирал Кент Чаплнттай холбоо тогтоож, эхний

ээлжинд давхар даатгалын гэрээ байгуулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх, “Lloyd’s” компанийн туршлагаас хуваалцах, техникийн туслалцаа үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах саналаа илэрхийлсэн. Энэ ажлын хүрээнд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 04/44 дугаар тушаалын дагуу Сингапур Улсад “Lloyd’s” болон “Swiss-Re” олон улсын давхар даатгалын компаниудтай уулзалт хийхээр Бизнес хөгжил, төслийн газрын дарга, Андеррайтингийн газрын дарга, Бизнес хөгжил, төслийн газрын төслийн менежер нар томилолтоор ажиллалаа.

2016 оны 7 дугаар сарын 28-ны өдөр “Swiss Re” олон улсын давхар даатгалын компанитай хийсэн уулзалтаар манай компанитай дараах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцлоо. Үүнд: Монгол Улсын газар тариалангийн салбарт индексэд суурилсан даатгалын бүтээгдэхүүн нэвтрүүлэх тал дээр дэмжлэг үзүүлж ажиллах, индексэд суурилсан газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүн боловсруулахад шаардлагатай тооцоолол болон судалгааг хийх, давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн ажилтнуудыг чадваржуулах тал дээр дэмжлэг туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах, урт хугацаагаар дадлага хийлгэх, Гамшгийн даатгалын чиглэлээр хамтран ажиллах зэрэг болно.

2016 оны 7 дугаар сарын 29-ний өдөр “Lloyd’s” олон улсын давхар даатгалын компанийн Сингапур Улс дахь суурин төлөөлөгчийн газартай хийсэн уулзалтын үеэр “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй танилцуулга хийв. МИД-ын бүтээгдэхүүн, шинээр хэрэгжүүлж буй үр тарианы даатгал болон Монгол Улсын Засгийн газраас бүтээн байгуулалт хийх томоохон төслүүдийн талаар дэлгэрэнгүй танилцуулга, цаашид “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн үйл ажиллагаа болон цар хүрээ хэрхэн тэлэх талаар “Lloyd’s” олон улсын давхар даатгалын компанийн Андеррайтеруудад танилцуулга хийж холбогдох асуултад хариулан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсрууллаа.

Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын зохицуулалтын газрын референттэй уулзаж, улаан буудайн даатгалын бүтээгдэхүүнтэй холбоотой Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, гэрээ, тооцоолол, судалгааг бэлтгэн хүргүүлээ.

3.4. Тариалангийн даатгалын тухай хууль, эрх зүйн орчны асуудлаар:

Хүнс, хөдөө аж ахуйн яамны сайдын 2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн тушаалаар Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10. дахь хэсэг, Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 6.1.5. дахь заалтыг баримтлан тариалангийн даатгалын тухай хуулийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд компанийн Ерөнхий хуульч, Андеррайтингийн газрын тариалангийн бүтээгдэхүүн хариуцсан андеррайтер нар орж ажиллаж байна.

Хуулийн ажлын хэсгийн эхний хурал 4 дүгээр сарын 25-ны өдөр хуралдаж, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-иас хэрэгжүүлж байгаа улаан буудайн даатгалын бүтээгдэхүүний талаар танилцуулга хийж, хэлэлцүүлээ. Мөн тус хурлаар хуулийн төслийн гол зарчмуудыг тодорхойлсон. Хуулийн ажлын хэсгийн 2 дахь хурал 5 дугаар сарын 06-ны өдөр хуралдаж, улаан буудайн даатгалын эдийн засгийн тооцооллыг боловсруулан хэлэлцүүлээ. Мөн тус хурлаар “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-иас бусад орнуудын тариалангийн даатгалын хуулиудын матрицыг танилцуулсан юм.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-иас хуулийн ажлын хэсэгт багтсан ажилтнууд хуулийн төслийг эхний байдлаар боловсруулсан бөгөөд холбогдох мэргэжилтэнүүдээс санал авч нэгтгэн, хуулийн ажлын хэсгийн бусад гишүүдээс санал авахаар хүргүүлээд байна.

Хуулийн ажлын хэсгийн шинэчлэгдсэн бүрэлдэхүүний анхны хуралдаан 2016 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр боллоо. Хуралдаанаар хуучин ажлын хэсгийн хийсэн ажлуудыг танилцуулсан бөгөөд дараагийн хуралдаанаар “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн боловсруулсан хуулийн төсөл болон бусад судалгааг хэлэлцэж, хуулийн үзэл баримтлалын төслөө боловсруулахаар боллоо.

3.5. Компанийн сургалт сурталчилгааны ажлын чиглэлээр:

Санхүүгийн зохицуулах хорооноос “Санхүүгийн зах зээлийн хөгжил” үндэсний форумыг 2016 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Монгол банк, Сангийн яам, Хөрөнгийн биржтэй хамтран зохион байгуулсан тус чуулганд банк, бичил санхүү, даатгал, хөрөнгийн зах зээл зэрэг санхүүгийн бүхий л салбарын зохицуулагч, бодлого боловсруулагч, зах зээлд оролцогч, судлаачдаас гадна гадаадын болон олон улсын байгууллагын 800 гаруй төлөөлөгчид оролцсон ба тус компанийг төлөөлөн Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын дарга болон бусад ажилтнууд оролцлоо.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн нийт ажилчдын дунд 2016 оны 5 дугаар сарын 06-ны өдөр МИД болон газар тариалангийн даатгалын талаар сургалт зохион байгуулсан. Мөн Бизнес хөгжил, төслийн газар Андеррайтингийн газартай хамтран албан тушаалтнуудад газар тариалангийн даатгалын талаар сургалт хийлээ. Сургалт хийснээр компанийн ажилтнууд мэдээлэлтэй болж, шинэ бүтээгдэхүүн болох улаан буудайн даатгалын талаар хүмүүст мэдээлэл өгөх боломжтой болсон.

Санхүүгийн зохицуулах хороо, Монголын даатгагчдын холбоо, Монголын актуарчдын нийгэмлэг хамтран 5 дугаар сарын 26-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны хооронд зохион байгуулсан актуарчийн сургалтанд Андеррайтингийн газрын МИД хариуцсан андеррайтер, Андеррайтингийн газрын даатгалын шинжээч нар хамрагдаж хүүгийн онол, моргейж, эрсдэлийн онол, амьдралын даатгалын бүтээгдэхүүний андеррайтинг, эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүний андеррайтинг, ердийн даатгалын бүтээгдэхүүний андеррайтинг, даатгалын төлбөрийн чадвар зэрэг сэдвүүдээр суралцсан.

Санхүүгийн зохицуулах хороо, Дэлхийн банкны “Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл”-тэй хамтран зохион байгуулсан Онол арга зүйн түвшинг

дээшлүүлэх мэдлэг олгох сургалтанд Андеррайтенгийн газрын бусад бүтээгдэхүүн хариуцсан андеррайтер хамрагдсан.

Япон улсын “JICA” байгууллагаас Нийгмийн даатгалын салбарын чадавхийг бэхжүүлэх техник хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлэх хүрээнд малчдыг хэрхэн нийгмийн даатгалд хамруулах талаар судалгааны ажлыг эхлүүлээд байна. Энэ төслийн хүрээнд “JICA”-тай хамтран хэрхэн малчдын малыг нь даатгах асуудлаар Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын дарга уулзалт зохион байгууллаа.

Газар тариалан хариуцсан андеррайтер 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулсан “Өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээг хийх аргачлал” сэдэвтэй сургалтанд хамрагдсан.

Япон Улсын Актуарын институтээс зохион байгуулсан “2016 оны Зүүн Азийн орнуудын актуарын семинар”-т “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийг төлөөлж Андеррайтингийн газрын газар тариалан хариуцсан андеррайтер 2016 оны 9 дүгээр сарын 13-ны өдрөөс 17-ныг хүртэлх хугацаанд амжилттай оролцоод ирсэн. Тус сургалтанд 10 улсын амьдралын болон амьдралын бус даатгалын мэргэжилтнүүд, актуарч нар оролцож, Япон Улсын болон бусад улсуудын туршлагаудаар мэдээлэл солилцсон байна. Тус улсын Актуарын институтээс Япон Улсын нийгмийн даатгалын хөтөлбөрүүд болон өнөөгийн байдал, амьдралын даатгалын зах зээлийн шилжилт, шинэ бүтээгдэхүүнүүд, актуарын санал бичих загвар, бүлгийн амьдралын даатгал, нас баралтын хүснэгт, амьдралын даатгалын нягтлан бодох бүртгэл, бүлгийн тэтгэврийн даатгал, төлбөрийн чадварын үзүүлэлтийн талаар танилцуулга хийж, харилцан санал солилцсон байна.

Хөрөнгийн зах зээлийн нээлттэй холбооноос 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан сургалтанд оролцов. Сургалт:

- Санхүүгийн шинжилгээ
- Олон улсын хөрөнгийн зах зээл
- Хөрөнгийн зах зээл дэхь форексийн нөлөө
- Санхүүгийн үүсмэл зах зээл эрсдэлийн удирдлага зэрэг сэдвүүдээр явагдав.

2016 оны 10 дугаар сарын 20-ны өдөр МИД хариуцсан андеррайтер компанийн ажилтнуудад МИД-ын мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор “МИД-ын ерөнхий зорилго” сэдэвт сургалт зохион байгуулсан.

Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хамтран 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан “Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем” сэдэвт сургалтанд санхүү, удирдлагын газрын дарга, дотоод хяналтын ажилтан нар хамрагдлаа.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн ажилтнуудад 10 дугаар сарын 28-ны өдөр Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын үйл ажиллагаа, сангийн хөрөнгийн зохицуулалт, бүрдэлт, хөрөнгийн байршилын талаарх мэдээлэл, сургалтыг, 11 дүгээр сарын 25-ны өдөр МИД-ын нөхөн төлбөр болон, Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалын нөхөн төлбөрийн сургалтыг тус тус зохион байгуулав.

Ус цаг уур, орчны шинжилгээний хүрээлэнгийн Хөдөө аж ахуйн цаг уурын секторын эрхлэгчтэй гэрээ байгуулан, компанийн ажилтнуудад хэрэгтэй мэдээллийг өгүүлэх зорилгоор 3 цагийн сургалт зохион байгуулав. Сургалтаар Монголын газар тариалангийн бүс нутгийн цаг уурын төлөв байдал болон нийт газар нутгийн ерөнхий байдлын талаар мэдээлэл авлаа.

Хүнс, хөдөө аж ахуйн яам, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК, МҮОНРТ хамтран “Уриншнаас ургац хүртэл” цуврал 10 нэвтрүүлгийг хийхээр гэрээ байгуулан ажилласан. Энэ нэвтрүүлгээр газар тариалангийн салбарын шинэ технологийг сурталчлан таниулах замаар үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлж даатгуулахын ач холбогдлыг олон нийтэд ойлгуулах зорилготой юм. Нэвтрүүлэг 4 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн түгээгдсэн.

Хамтын ажиллагааны хүрээнд “Малчин” телевизтэй 2 дугаар сарын 18-ны өдөр 6 сарын хугацаатай гэрээ байгуулж зар сурталчлага болон нэвтрүүлэг, мэдээ бэлтгүүлэн өдөр тутам түгээж байна. Гэрээний хугацаанд манай байгууллагын бүхий л үйл ажиллагааг хөдөө орон нутаг, малчдад мэдээлэл хүргэх, сурталчлах боломжтой боллоо. Мөн 21 аймгийн Засаг даргын тамгын газрын хэвлэл мэдээлэл болон мэргэжилтнүүдтэй холбоо тогтоон ажиллаж байна. МИД-ын талаар 2 нэвтрүүлэг бэлтгэн 2 дугаар сарын 28-ны орой МҮОНРТ-ийн 1-р суваг, “Малчин” телевизээр давталттай гаргасан. Мөн компанийн шторк гурвыг хийлгэн телевиз болон олон нийтийн сүлжээ нүүр номын хуудас, youtube-д байршууллаа.

“Bloomberg” телевизэд газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүний талаар ярилцлага өгч, сонирхсон асуултанд хариулт өглөө. “Шинэ тариаланч” сэтгүүлд газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүний талаар мэдээ бэлтгэн өгч нийтлүүлсэн. Мөн 3 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдсан Тариалангийн даатгалын зөвлөлдөх уулзалтын арга хэмжээг хэвлэл мэдээллийн 20 гаруй байгууллагаар дамжуулан олон нийтэд сурталчилсан.

Сар шинийн баярыг тохиолдуулан компанийн Гүйцэтгэх захирал хөдөө орон нутгийн малчдад сар шинийн мэндчилгээг “Малчин” телевизээр дамжуулан хүргэсэн. Компанийн лого, нэр бүхий сар шинийн мэндчилгээг хийн, хамтран ажилладаг албан байгууллага хувь хүмүүст илгээсэн.

Улаан буудайн даатгалын тухай дэлгэрэнгүй мэдээлэл болон компанийн тухай товч танилцуулга, нугалбарын мэдээллийг бэлдэж, хэвлэлийн ерөнхий загварыг гаргаж, “Мөнхийн үсэг” ХХК-д захиалж хэвлүүлэв. Мөн Малын индексжүүлсэн даатгал төслөөс эрхлэн гаргасан “Даатгал” сонинд улаан буудайн даатгалын талаар танилцуулга бэлтгэж хэвлүүлсэн.

Улаан буудайн даатгалын тухай 1 минут гаруй хугацааны шторкийг “Харандааны адал явдал” нэвтрүүлгийн загвараар хийлгэхээр болж, “Сүүдэр” студитэй гэрээ байгуулж, хамтран ажиллав. Шторкийн зохиолыг хамтран бичиж, улаан буудайн даатгалын ашиг тусын тухай 1 минут 54 секундын шторкийг бэлтгэн түгээлээ.

Компанийн нүүр номын хуудсыг /facebook/ өдөр тутам хөтөлж байна. Аймгуудын нүүр номын хуудсан дээр болон нэгдсэн заруудад компанийн нүүр номын хуудаст нийтэлсэн “Бэлчээрийн менежмент” цуврал мэдээг тогтмол

хуваалцаж байна. Бүлгийн уулзалт зохион байгуулсан тухай цахим хуудас болон нүүр номын хуудсанд /facebook/ нийтлэв.

"Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК-ийн брэндин, лого, албан бичгийн стандартыг дахин шинэчилж боловсруулж хийх ажлын гүйцэтгэгийг шалгаруулахаар загварын компаниудаас үнийн санал авч бага үнийн санал өгсөн "BSP solutions" ХХК-тай ажил гүйцэтгэлийн гэрээ байгуулан ирсэн загваруудад санал өгч, эцэслэн боловсруулж бэлэн болголоо.

"Малчин" телевизийн цаг агаарын нэвтрүүлгийн дараа 6 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн сарын хугацаанд өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээний нэр, лого, уриалгыг байршуулж малчдад сурталчиллаа.

МҮОНРТ-ийн Хурд агентлагтай хамтран ажиллах гэрээ байгуулж, малчдын асуултад эфирын утсаар хариулах, малчдад мэдээлэл өгөх зорилгоор "Малчны лавлах" нэвтрүүлэгт компанийн төлөөллийг оруулав. Нэвтрүүлэг 30 минутын турш МҮОНРТ-ын 1 болон 2 дугаар сувгаар давталттайгаар оргил цагт гарлаа. Энэхүү нэвтрүүлэг зурагт болон радиогоор малчдад хүрсэн юм.

"Юнител" компаниас зохион байгуулсан даатгалд ашиглах харилцааны холбооны шийдэл болон бусад байгууллагад зориулсан үйлчилгээг танилцуулах уулзалтад оролцон, компанийнхаа удирдлага, ажилтнуудад саналыг танилцуулав.

МИД-ын нөхөн төлбөр олголтоор компанийн удирдлагууд болон ажилтнууд хөдөө орон нутагт ажиллахдаа телевизийн зураглаачаар дүрс, ярианы бичлэг хийлгэн баталгаажуулж, нэвтрүүлэг бэлтгэхэд ашигласан. Мөн нөхөн төлбөр олгох болсонтой холбоотойгоор шторкийг хийж өөрийн цахим хуудас, нүүр номын хуудсанд /facebook/ байршууллаа.

ДӨРӨВ. ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА, НӨХӨН ТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Компанийн сангийн хөрөнгийг удирдах, зохицуулах чиглэлээр:

Алдагдлаас хамгаалах сангийн болон эрсдэлээс хамгаалах сан, нөөц сангийн хөрөнгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан "Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ыг мөрдлөг болгон доорх байдлаар байршууллаа.

Сангуудын нэршил	Сангийн хөрөнгийн байршил	Хэмжээ	Нийт хөрөнгөд эзлэх хувь
Алдагдлаас хамгаалах сан 1/3	Голомт банк	1,000,000,000.00	5.8
	ХААН банк	1,000,000,000.00	5.8
	Капитал банк	1,500,000,000.00	8.6
	Хас банк	1,500,000,020.00	8.6
Алдагдлаас хамгаалах сан 2/3	ХААН банк	2,000,000,000.00	11.5
	Голомт банк	800,000,000.00	4.6
	Капитал банк	1,000,000,000.00	5.8
	Улаанбаатар хотын банк	700,000,000.00	4.0

МИД төслөөс хүлээн авсан	Капитрон банк	2,000,000,000.00	11.5
Дээд түвшин	Улаанбаатар хотын банк	1,400,000,000.00	8.1
Дунд түвшин	Хас банк	148,703,914.00	0.9
Нөөц сан	Голомт банк	1,400,000,000.00	8.1
	Төрийн банк	1,400,000,000.00	8.1
	Улаанбаатар хотын банк	1,500,000,000.00	8.6
Газар тариалангийн нөөц сан	Хас банк	2,054,872.00	0.01
Нийт		17,350,758,806.00	100.0

Алдагдлаас хамгаалах сангийн 1/3 болох 5.0 тэрбум төгрөгийн байршил:

ХААН, Төрийн, Худалдаа хөгжлийн, Хас банкууд дахь Алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгө болох 5.0 тэрбум төгрөгийн хадгаламжууд 2016 оны 1 дүгээр сарын 13,14-ны өдрүүдэд хугацаа дууссан тул хадгаламжийг Төрийн банкны харилцах дансанд татаж, дахин байршуулахаар арилжааны банкнуудаас хүүгийн санал авсан. Энэхүү саналаар манай компанийн шалгуурыг хангасан Голомт банкинд 2016 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 1 тэрбумийг 16.8 хувийн хүүтэйгээр, 2016 оны 1 дүгээр сарын 19-ны өдөр Хас банкинд 1.5 тэрбумийг 16.8 хувийн хүүтэйгээр 0.5 хувийн хүүг хугацааны эхэнд Төрийн банкны харилцах дансандаа авч, 2016 оны 1 дүгээр сарын 19-ны өдөр Хаан банкинд 1.0 тэрбумийг 16.1 хувийн хүүтэйгээр, Капитал банкинд 1.5 тэрбум төгрөгийг 16.3 хувийн хүүтэйгээр 2016 оны 1 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн нэг жилийн хугацаатай тус тус байршууллаа.

Алдагдлаас хамгаалах сангийн 2/3-ын эхний хэсэг 4.5 тэрбум төгрөгийн байршил:

Сангийн яамнаас 2016 оны 2 дугаар сарын 29-ний өдөр Алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийн 2/3 хэсэг болох 2,500,000,000.00 /хоёр тэрбум таван зуун сая/ төгрөгийг компанийн харилцах дансанд хүлээн авч, арилжааны 6 банкнаас хүүгийн санал авч шалгаруулан:

1. Капитал банкинд 1,000,000,000.00 /нэг тэрбум/ төгрөгийг 16.3 хувийн хүүтэй,
2. Голомт банкинд 800,000,000.00 /найман зуун сая/ төгрөгийг 16.8 хувийн хүүтэй,
3. Улаанбаатар хотын банкинд 700,000,000.00 /долоон зуун сая/ төгрөгийг 16.7 хувийн хүүтэйгээр 1 жилийн хугацаатай байршуулж, хадгаламжийн гэрээ хийсэн.

Мөн сангийн хөрөнгө болох ХААН, Төрийн банкин дахь нийт 2.0 тэрбум төгрөгийн хадгаламжууд 2016 оны 4 дүгээр сарын 16,17-ны өдрүүдэд хугацаа дуусаж 2.0 тэрбум төгрөгийг 16.1 хувийн хүүтэйгээр нэг жилийн хугацаатай ХААН банкинд хадгаламж хэлбэрээр байршууллаа.

Алдагдлаас хамгаалах сангийн 2/3-ын дутуу хэсэг 5.5 тэрбум төгрөгийн байршил:

Алдагдлаас хамгаалах сангийн бүрдүүлэлтийн 3 дахь хэсэг болох 5.5 тэрбум төгрөгийг улсын төсвөөс төвлөрүүлэх ажлын хүрээнд 2016 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Сангийн яамны Санхүүгийн бодлогын газарт шийдвэрлэж өгөхийг хүссэн албан бичиг явуулсан.

Мөн 2016 оны 8 дугаар сарын 29-ны өдөр Сангийн яамны Санхүүгийн бодлогын газарт төсвийн хүрээний мэдэгдэл хүргүүлж, Алдагдлаас хамгаалах сангийн бүрдүүлэлтийн 3 дахь хэсэг болох 5.5 тэрбум төгрөгийг 2017 оны Улсын төсөвт суулгаж өгөхийг хүссэн албан тоот явуулснаас тус санд 2017 оны Улсын төсөвт 3.5 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд санхүүжилтийг 2017 оны 4 дүгээр сард хүлээн авна гэж төлөвлөж байна.

МИД төслийн хуримтлагдсан нөөц хөрөнгийн байршил:

МИД төслийн хэрэгжих хугацаа дуусаж 10 жилийн хугацаанд хуримтлагдсан нөөц сангийн хөрөнгө болох 2,184,576,836.27 төгрөгийг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн харилцах дансанд 2016 оны 5 дугаар сарын 09-ны өдөр хүлээн авсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 5 дугаар сарын 31-ны өдрийн 02/04Б дугаар тогтоолоор 2.0 тэрбум төгрөгийг нь Капитрон банкинд 1 жилийн хугацаатай, жилийн 16.0 хувийн хүүтэйгээр байршууллаа. Мөн 6 дугаар сарын 03-ны өдөр дээрх харилцах дансны хүүнд 1,081,129.97 төгрөг хүлээн авлаа.

МИД-ын Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгийн байршил:

Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгө болох 446.5 сая төгрөгийн хадгаламж 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдөр дуусгавар болж хадгаламжийг Төрийн банкны харилцах дансанд татан авсан. 2016 оны МИД-ын дээд түвшний нөөц санд 400.0 сая төгрөг Төрийн сангаас 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авч компанийн нөөц сангийн хөрөнгөтэй нийлүүлэн 1.4 тэрбум төгрөг болгон байршуулахаар болсон. Арилжааны банкуудаас хүүгийн санал авч Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 02/08 дугаар тогтоолын дагуу Улаанбаатар хотын банкинд дээрхи 1.4 тэрбум төгрөгийг 1 жилийн хугацаатай, жилийн 16.0 хувийн хүүтэйгээр, хүүг сар бүр авах нөхцөлөөр байршууллаа.

МИД-ын Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгийн байршил:

Дунд түвшний давхар даатгалын хураамжийн хөрөнгөнд 60.0 сая төгрөгийг 2016 оны 2 дугаар сарын 18-ны өдөр Хас банкинд нэг жилийн хугацаатай, 16.3 хувийн хүүтэй байршуулсан байсан. 2016 оны 12-р сарын 26-ны өдрийн Гүйцэтгэх захирлын 04/89 дугаар тушаалаар дунд түвшний нөөц санд 2016 оны МИД-ын нийт хураамжийн 5 хувь болох 88,703,914.04 төгрөгийг нэмж байршуулаад байна.

Дүрмийн сангийн хөрөнгийн байршил:

2016 оны 10 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд “Новел Инвестмент” ҮЦК, “Гүүдсек” ҮЦК-иудаар дамжуулан худалдан авсан 2.85 тэрбум, 11 дүгээр сарын 07-ны өдөр Сангийн яамаар хаалттай хэлбэрээр худалдан авсан 16.6 тэрбум төгрөг хүлээн авч, нийт 19.5 тэрбум төгрөг орж ирсэн. 2016 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын дагуу 11 дүгээр сарын 8-ны өдөр нэг жилийн хугацаатай Засгийн газрын үнэт цаасыг 6.6 тэрбум төгрөгөөр, 11 дүгээр сарын 15-ны өдөр 6 сарын хугацаатай Засгийн газрын үнэт цаасыг 8.4 тэрбум төгрөгөөр, нийт 15.0 тэрбум төгрөгөөр Засгийн газрын үнэт цаас худалдан авсан. Үлдэгдэл 4.5 тэрбум төгрөгийг нөөц сангийн хөрөнгө рүү шилжүүлсэн.

Нөөц сангийн хөрөнгийн байршил:

Засгийн газрын үнэт цаасны хөрөнгийн үлдэгдэл болох 4.5 тэрбум төгрөгөөс арилжааны банкинд байршуулахаар санал авч Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 11 дүгээр сарын 01-ны өдрийн 02/11

дугаар тогтоолын дагуу Голомт банкинд 1.4 тэрбум төгрөгийг жилийн 17.4 хувийн хүүтэйгээр, Төрийн банкинд 1.4 тэрбум төгрөгийг жилийн 16.1 хувийн хүүтэйгээр, Улаанбаатар хотын банкинд 1.5 тэрбум төгрөгийг жилийн 16.1 хувийн хүүтэйгээр, хүүгийн орлогыг сар бүр харилцах дансандаа авч байхаар гэрээ байгуулж нийт 4.3 тэрбум төгрөг байршууллаа.

Газар тариалангийн даатгалын сангийн хөрөнгийн байршил:

Газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүний нөөц сангийн 2,054,871.90 төгрөгийг 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Гүйцэтгэх захирлын 04/88 дугаар тушаалаар Хас банкинд 9 сарын хугацаатай жилийн 14.1 хувийн хүүтэйгээр байршуулаад байна.

4.2. Хөрөнгө оруулалтын орлогын бүрдүүлэх чиглэлээр:

Банкуудтай байгуулсан харилцах, хадгаламжийн гэрээний дагуу ХААН, Капитал болон Капитрон банкуудын хүүгийн орлого хугацаандаа орж ирээгүй учраас хүүгийн алданги тооцож, нийт 7,759,146.70 /долоон сая долоон зуун тавин есөн мянга нэг зуун дөчин зургаан төгрөг далан мөнгө/ төгрөгийн алданги орлого оруулж, 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар нийт 1,846,939,270.68 /нэг тэрбум найман зуундөчин зургаан сая есөн зуун гучин есөн мянга хоёр зуун далан төгрөг жаран найман мөнгө/ төгрөгийн хадгаламжийн хүүгийн орлого, 74,819,343.24 /далан дөрвөн сая найман зуун арван есөн мянга гурван зуун дөчин гурван төгрөг хорин дөрвөн мөнгө/ төгрөгийн харилцахын хүүгийн орлогыг тус тус олж, нийтдээ харилцах болон хадгаламжийн хүүнд 1,929,517,760.58 /нэг тэрбум есөн зуун хорин есөн сая таван зуун арван долоон мянга долоон зуун жаран төгрөг тавин найман мөнгө/ төгрөг оруулсан.

Засгийн газрын үнэт цаасны хүүгийн орлогоос 2016 онд нийт 2,474,989,101.50 /хоёр тэрбум дөрвөн зуун далан дөрвөн сая есөн зуун наян есөн мянга нэг зуун нэг төгрөг тавин мөнгө/ төгрөгийн орлого олсон байна.

Тайлант онд харилцах болон хадгаламжийн хүү, бондын хүү, алдангиас нийт **4,404,506,862.12 /дөрвөн тэрбум дөрвөн зуун дөрвөн сая таван зуун зургаан мянга найман зуун жаран хоёр төгрөг арван хоёр мөнгө/** төгрөгийн орлого оллоо.

Банкуудтай байгуулсан 2016 оны харилцах, хадгаламжийн гэрээ болон бондын гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж харилцах, хадгаламжийн хүүгийн тооцоолол болон бондын өгөөжийн тооцооллыг сар бүр хийж компанийн нягтлан бодох бүртгэлийн дансанд бүртгэсэн. Хугацааны эцэст орж ирэх хадгаламжийн хүү болон бондын өгөөжийг нягтлан бодох бүртгэлд авлага хэлбэрээр бүртгэж байна.

4.3. Нөхөн төлбөрийн тооцоолол, олголтын чиглэлээр

МИД-ын нөхөн төлбөрийг олгох:

2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 7 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд МИД-д хамрагдсан аймгуудаас 5 хувийн хорогдлын босго үзүүлэлттэй Архангай, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Сүхбаатар, Төв, Дорнод, Ховд аймгууд, 6 хувийн хорогдлын босго үзүүлэлттэй Баянхонгор, Дундговь, Завхан, Увс аймгуудад хорогдлын босго үзүүлэлтүүдийг давсан тул нөхөн төлбөр олгогдохоор болсон.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан малын тооллогын дүнд үндэслэн, хорогдлын босго үзүүлэлтийг давсан дээрх 12 аймгийн 61 сумын 3,133 малчин

өрхөд нийт 413,638,948.00 /дөрвөн зуун арван гурван сая зургаан зуун гучин найман мянга есөн зуун дөчин найман/ төгрөгийн нөхөн төлбөрийг олгох дүн мэдээ гарсан. Аймгуудын нөхөн төлбөр авсан байдлыг доорх хүснэгтээр үзүүлээ:

№	Аймаг	Малчин өрхийн тоо	Нөхөн төлбөрийн дүн
1	Архангай	162	5,224,403.93
2	Баянхонгор	946	86,690,214.86
3	Булган	51	4,749,241.42
4	Говьсүмбэр	5	926,021.00
5	Дорноговь	227	48,910,564.52
6	Дорнод	38	663,325.00
7	Дундговь	29	3,581,644.20
8	Завхан	97	8,297,889.85
9	Сүхбаатар	198	57,235,286.85
10	Төв	97	5,279,545.33
11	Увс	1,227	188,022,852.03
12	Ховд	56	4,057,959.39
Нийт		3,133	413,638,948.38

Үүнээс хамгийн их нөхөн төлбөр авсан сумаар Увс аймгийн Өндөрхангай сум 121,479,715.66 төгрөгний, хамгийн бага нөхөн төлбөр авсан Төв аймгийн Баян-Өнжүүл сум 17,500 төгрөгний нөхөн төлбөр авсан байна. Хамгийн өндөр нөхөн төлбөр болох 4,465,860.00 төгрөгийг Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын малчин М.Амаржаргал авсан байна.

МИД-ын 2015 оны хураамжийн орлого 1 тэрбум 317 сая төгрөгийг, олгосон нөхөн төлбөр 413.6 сая төгрөгтэй харьцуулвал 31.4 хувийг эзэлж байна.

Дорноговь аймгийн Айраг суманд үхрийн хорогдол 25.27 хувь, Дэлгэрэх суманд мөн үхрийн хорогдол 29.01 хувь, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр суманд үхрийн хорогдол 32.27 хувь, адууны хорогдол 25.92 хувь гарч тус аймгуудын хоёрдугаар босго үзүүлэлт болох 25 хувиас давж дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангаас нөхөн төлбөр олгохоор болсон.

МИД-ын 2015 онд борлуулалт хийсэн 6 даатгалын компанид нөхөн төлбөр болох 413.6 сая төгрөгийг Хамтын эрсдэлийн сан болон Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангаас гарган шилжүүлж, нөхөн төлбөр хэрхэн олгох, тайлагнах зааврыг хүргүүлж ажиллалаа. Нөхөн төлбөрийг 8 дугаар сарын 15-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд бүрэн олгож дууссан ба оролцогч даатгагч нараас холбогдох тайланг бэлтгүүлэн авсан.

Өндөр нөхөн төлбөр гарсан Увс аймгийн сумуудад 8 дугаар сарын 15-23-ны өдрүүдэд, Сүхбаатар, Дорноговь аймгуудын зарим сумдуудад 9 дүгээр сарын 2-7-ны өдрүүдэд очиж нөхөн төлбөрийг гардуулан, малчдаас ярилцлага авах, хэвлэл мэдээллээр сурталчлах ажилд компанийн удирдлага, ажилтнууд оролцлоо.

Оролцогч даатгагчдын ашиг хүртэх /алдагдал хүлээх/, Олон улсын давхар даатгагчдаас нөхөн төлбөр авах эсэх тооцооллыг хийж, холбогдох гүйлгээнүүдийг хийж ажилласан.

Хамтын эрсдэлийн сангаас малчдад олгох нөхөн төлбөрийг гарган, мөн 45.0 сая төгрөгийг Хамтын эрсдэлийн сангийн хуримтлал үүсгэхээр хадгаламжийн дансанд байршуулав. Хамтын эрсдэлийн сангийн үлдэгдэл болон хадгаламжийн хүүгийн орлого 215.0 сая төгрөгийг 6 даатгалын компанид хуваарилав.

Нийт оролцогч даатгагч, зуучлагч банкуудын борлуулалтыг дүгнэн нэгтгэх, цаашлаад давхар даатгалын хураамж, хамтын эрсдэлийн санг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Тариалангийн даатгалын нөхөн төлбөрийг олгох:

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын “Өгөөж Мандал уул” ХХК-ийн тарьсан 212 га улаан буудайн талбай мөндөрт цохиулсан гэсэн дуудлагыг даатгуулагчаас 7 дугаар сарын 27-ны өдрийн 17 цаг 20 минутад авч, 7 дугаар сарын 28-ны өдөр талбай дээр очиж, үзлэг шалгалт хийлээ. Нийт 212 га талбайгаас мөндөрт цохиулсан хэсэг болох 50 га талбайд хэмжилт хийж эрсдэлийг тооцоолох ажлыг зохион байгуулав.

Мөн компанийн даатгуулсан талбайд буудайн урьдчилсан ургац тогтоолтыг тооцох ажлын хэсэг 2016 оны 8 дугаар сарын 25-ны өдөр томилогдон ажилласан. Буудай тариалсан 212 га талбайд 1 кв.м жаазыг санамсаргүй байдлаар байрлуулж мөндөр цохисон хэсгээс 3 цэгт, бусад хэсгээс 8 цэгт ургац тодорхойлох ажлыг зохион байгуулав. Урьдчилсан ургац тогтоолтоор мөндөр цохисон талбайн ургац 10.03 ц/га, бусад талбайн ургац 16.28 ц/га, дунджаар 13.18 ц/га байв. Ургац тогтоолт 10 ц/га-аас дээш байгаа тул нөхөн төлбөр олгогдохгүй болох нь тогтоогдсон.

2016 оны 9 дүгээр сарын 12-ны өдрөөс 20-ны өдрүүдэд “Өгөөж Мандал уул” ХХК нь нийт 250 га талбайгаас 275.0 тн улаан буудайн ургац хурааж, эцсийн байдлаар дундаж ургац нь 10.1 цн/га авч, даатгалын гэрээнд даатгуулсан дундаж ургацаас өндөр гарсан байна. Иймд эцсийн байдлаар даатгуулагч нөхөн төлбөр авахгүй болох нь баталгаажлаа.

4.4. Судалгааны чиглэлээр:

Компанийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын шинэ суваг эрэлхийлэх зорилгоор “Хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх, Хөрөнгө оруулалтын менежментийн компанитай хамтран ажиллах, хөрөнгөө удирдуулах тухай” судалгааны ажил хийж Гүйцэтгэх удирдлагад танилцуулсан. Энэ судалгаагаар “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь хөрөнгө оруулалтын сан байгуулах боломж, ямар хэлбэрээр энэ сангуудад хөрөнгө оруулалт хийх боломжтой байх, сан байгуулах болон санд хөрөнгө оруулахад үүсэх давуу болон сул талууд, хөрөнгө оруулалтын менежментийн компанитай хамтран ажиллах боломж, менежментийн компаниар хөрөнгөө удирдуулахын давуу болон сул талыг судлахыг зорьсон.

Судалгааг хийхдээ “Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”, даатгалын компанийн “Дүрмийн болон нөөцийн сангаас хөрөнгө оруулалт хийх журам”, “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны тухай журам” зэрэг даатгалын компани

хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх эрх зүйн орчинг судалж үнэлэлт дүгнэлт гаргасан. Судалгааны ажлыг:

1. Оршил
2. Дэлхий дахинд хөрөнгө оруулалтын сангийн үүсэл хөгжил, өнөөгийн байдал
3. Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа
4. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаа
5. Монгол Улсад хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчин
6. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх боломж
7. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь менежментийн компанитай хамтран ажиллах, хөрөнгөө удирдуулах боломж
8. Монголд үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани болон сангуудын судалгаа
9. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтын менежментийн компанитай хамтран ажиллах давуу тал буюу ямар ашигтай вэ? /Дүгнэлт/ гэсэн есөн дэд сэдвийн хүрээнд хийлээ.

Мөн Багцийн удирдлага ба хөрөнгө оруулалтын сан-АТТФ, Investment Company Factbook 2015, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ХК зэрэг гадаад, дотоодын санхүүгийн байгууллагуудын тоон мэдээллийн эх сурвалжийг ашиглаж “Дэлхий дахинд Хөрөнгө оруулалтын сангийн өнөөгийн байдлын тойм судалгаа”, “АНУ-ын Хөрөнгө оруулалтын сангийн нийт хөрөнгийн судалгаа”, “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн үнэт цаасны зах зээлийн тойм судалгаа”, “Үл хөдлөх хөрөнгийн үнийн зах зээлийн тойм судалгаа” гэсэн зах зээлийн тойм судалгаануудын бодит тоон үзүүлэлтүүд дээр дүн шинжилгээ хийж гаргасан.

ТАВ. САНХҮҮ, УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1. Компанийн хүний нөөц, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын чиглэлээр:

Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт өөрчлөлт хийж, шинэчлэгдсэн төслийг бэлэн болгон удирдлагууд болон газрын дарга нарт хүргүүлж саналыг нь авч Захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлууллаа.

Компанийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Гүйцэтгэх захирлын 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 04/15 дугаар тушаалаар байгуулж ажиллуулсан. Ажлын хэсэг нийт 25 ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн буюу шинээр боловсруулан батлууллаа. Мөн компанийн ажилтнуудын хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулав.

Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр “Өсвөрийн зохион бүтээгчдийн лаборатори” ахлах сургуулийн спорт заалыг 7 хоногийн Мягмар гарагийн 17:30-19:30 цагийн хооронд ашиглаж байхаар хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. Амралтын өдрөөр ажилтнуудын дунд ууланд алхах, цэвэр агаарт гарах хөдөлгөөн өрнүүлэн ажиллаж байна.

Ажилтнуудыг хөдөлгөөний дутагдлаас хамгаалах, чийрэгжүүлэх зорилгоор “Golden gym” фитнес клубтэй хамтран ажиллах гэрээ байгуулан 9 дүгээр сараас эхлэн компанийн ажилтнууд хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэх боломжтой боллоо. Мөн “Steford” эрүүлжүүлэх төвд 8 ажилтан дасгалын дугуй /spinning/-аар хичээллэж эхлээд байна.

Цасны баярыг 1 дүгээр сарын 09-ний өдөр батлагдсан хөтөлбөрийн дагуу хамт олны дунд зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд зохион явуулсан хөгжөөнт уралдаан тэмцээнүүдэд ажилтнууд идэвх, санаачлагатай оролцлоо.

Жил бүр зохиогддог Сангийн сайдын нэрэмжит санхүү, эдийн засгийн салбарын төрийн байгууллагуудын хооронд явагдсан спорт тэмцээнд 4 дүгээр сарын 28-ны өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг дуустал хугацаанд баг тамирчдаа амжилттай зохион байгуулж оролцлоо.

Шинээр батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-тай танилцуулах сургалтыг 2016 оны 5 дугаар сарын 20-ны өдөр зохион явуулав.

Компани үүсэн байгуулагдсаны 2 жилийн ойн өдөрлөгийн арга хэмжээг 9 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан.

Даатгалын компаниудын дунд жил бүр зохиогддог Спортын их наадмын спорт тэмцээнд 11 дүгээр сарын 18-ны өдрөөс 20-ны өдрийг дуустал хугацаанд баг тамирчдаа амжилттай зохион байгуулж оролцлоо.

5.2. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Нягтлан бодох бүртгэлийн өдөр тутмын гүйлгээг Юникус санхүүгийн программ хангамжийг ашиглан хийж байгаа бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтуудыг тухай бүр нь бүрдүүлэн ажилласан. Гүйцэтгэх удирдлагад цаг тухай бүрд нь санхүүгийн мэдээллийг танилцуулж байгаа ба хэтрэх магадлалтай зардлын талаар саналаа улирал тутам хүргүүлж байна. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтуудыг дугаарлаж ашиглаж эхэлсэн ба ажил гүйлгээ гарсныг нотлох бусад баримтуудыг зохих журмын дагуу бүрдүүлж байна. Томилолтын зардлын тооцоо, тайлан, нотлох баримтуудыг холбогдох ажилтнуудаас гаргуулж авч байна. Жижиг мөнгөн сангийн гүйлгээг бэлэн мөнгөөр хийхээ больж, Голомт банкны картаар хийж гүйцэтгэдэг болсон. Мөн мөнгөний үлдэгдлийн тулган баталгаажуулалтыг тухай бүрт нь хийж, тооцоо нийлж байна.

Монгол Улсын Засгийн газрын www.shilendans.mn сайтад өөрийн байгууллагыг бүртгүүлж нийт 3 дэд хэрэглэгч үүсгэн, ажил үүргийн чиглэлийн дагуу мэдээллийг уг сайтад оруулах боломжтой болсон. Нягтлан бодох бүртгэлийн өдөр тутмын мэдээлэх гүйлгээ болон холбогдох бусад мэдээллийг цаг тухай бүрт нь шилэн дансанд мэдээлж байна.

Цагийн бүртгэлийн системийн мэдээллийг бүрэн гүйцэд боловсруулах боломжтой болсон. Мэдээллийг буруу оруулсны улмаас цагийн бүртгэлийн дэлгэрэнгүй мэдээллийг боловсруулж чадахгүй байсныг засаж залрууллаа.

2015 оны санхүүгийн тайланг 2016 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн дотор Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Сүхбаатар дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. 2016 оны 1, 2 дугаар улирлын тайланг Санхүүгийн

зохицуулах хороо, Сангийн яаманд хуулийн хугацаанд тайлагнан, цахим болон цаасаар илгээсэн ба татварын болон нийгмийн даатгалын сар, улирлын тайланг хуулийн хугацаанд цаас болон цахимаар хүргүүлэн ажиллалаа. Ажилтнуудын нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрт сар бүр бичилт хийн баталгаажуулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу “Нийслэл аудит” ХХК-д санхүүгийн баримтуудыг хүлээлгэн өгч аудит хийлгэв. Аудитын компаниас ирүүлсэн зөвлөмжийн дагуу холбогдох залруулга, арга хэмжээг авч хэрэгжүүлсний үндсэн дээр аудитлагдсан санхүүгийн тайланг Сүхбаатар дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэл бодлогын газар, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус хүргүүллээ. 2015 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын ирүүлсэн зөвлөмжийн дагуу алдаатай бичилтүүдийг засаж бүртгэсэн ба сангуудын хүүгийн орлогын зарцуулалтын судалгаа хийж сангуудаа өсгөх төлөвлөгөөний төслийг бэлтгэн гүйцэтгэх удирдлагад танилцуулсан.

Мөн “Нийслэл аудит” ХХК-тай иж бүрэн “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулах гэрээ байгуулан ажиллаж байна. Уг баримт бичгийн төсөлд “Эрсдэлийн сан”-гийн бүртгэлээс бусад бүлэг нь бүрэн тусгагдаад байгаа ба Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батлах “Дунд болон дээд түвшний эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах журам” батлагдаагүй байгаагаас хүлээлт үүсээд байна.

Сангийн сайдын 2016 оны 5 дугаар сарын 16-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Сангийн яамны төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс тус компанийн үйл ажиллагаанд дотоод аудитыг 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдрөөс 6 дугаар сарын 24-ны өдрийн хооронд хийсэн. Дотоод аудитын тайлангаар ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах ажлын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Энэ ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Компанийн 2017 оны санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төслийг газар нэгж тус бүрээр гаргуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулахад бэлэн болголоо.

5.3. Компанийн худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх чиглэлээр:

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу оффисын байрны түрээсийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2016 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр зарласан ба тендерийн нээлтийг 2016 оны 2 дугаар сарын 04-ний өдөр хийж үнэлэхэд оролцсон тендерүүд шаардлага хангаагүй тул бүх тендерээс татгалзав. Тендерийг дахин 2016 оны 2 дугаар сарын 18-ны өдөр зарлаж, 3 дугаар сарын 21-ний өдөр нээж, үнэлгээ хийв. 4 байгууллага тендер ирүүлснээс “Булнайн Ар” ХХК шалгарлаа. Шалгарсан компанитай оффисын байр түрээслэх гэрээ байгуулан хэрэгжүүлж байна.

Компанийн 2015 оны худалдан авах үйл ажиллагааны баримт бичгийн бүрдүүлэлт, хадгалалтыг хариуцан, хуулийн дагуу бүрдүүлэн хадгалж аудитын шалгалтаар оруулав.

Компанийн 2017 оны Худалдан авалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу оффисын байрны түрээсийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдөр зарласан ба 2017 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр нээж, үнэлгээ хийнэ.

Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 02/15 дугаар тогтоолоор 2016 оны Худалдан авалтын ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн заалтын дагуу туулах чадвар сайтай суудлын автомашин худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулах аргаар зохион байгууллаа.

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн МИД төслийн үйл ажиллагаа 2016 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болж байгаатай холбогдуулан төслийн хүрээнд бий болсон үндсэн болон биет хөрөнгө, мөнгөн хөрөнгийг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-д хүлээлгэн өгөх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах талаар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А/70 дугаар тушаал гарч Ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Энэхүү үйл ажиллагаатай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2016 оны 04/17 тоот тушаалаар “Малын индексжүүлсэн даатгал” төслөөс шилжин ирж байгаа биет болон санхүүгийн хөрөнгийг хүлээн авах ажлыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан эдгээр хөрөнгийг хүлээн авах ажлыг гүйцэтгэсэн. Төслөөс 37.3 сая төгрөгийн үнэлгээ бүхий тавилга, эд хогшил, 99.1 сая төгрөгийн үнэ бүхий автомашин, 264.0 сая төгрөгийн үнэ бүхий МИД-ын программ, 197.4 сая төгрөгийн үнэ бүхий датабааз, мөнгөн хөрөнгө 2,185.3 сая төгрөг, нийт 2,783.1 сая төгрөгийн биет болон санхүүгийн хөрөнгийг хүлээн авлаа.

Үндсэн хөрөнгийн тооллогыг Гүйцэтгэх захирлын 2016 оны 04/23 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс 30-ны өдрийг хүртэл хугацаанд хийж МИД-ын төслөөс хүлээн авсан болон өөрийн бүртгэлээр байгаа үндсэн хөрөнгийг тоолж баталгаажууллаа. Тооллогоор 29 ажилтны 165 ширхэг бүхий нийт 410,158,160.00 төгрөгийн балансын дүнтэй 350,869,470.49 төгрөгийн үлдэх өртөг бүхий эд хөрөнгө болон МИД төслөөс хүлээн авсан 257 тоо ширхэг бүхий 712,190,649.67 төгрөгийн дүнтэй 597,856,252.50 төгрөгийн үлдэх өртөг бүхий эд хөрөнгийг хамруулсан. Мөн компанийн ажилчдын ашиглаж буй эд хөрөнгийг шинэчлэн картлаж, дугаарлан бүртгэлээ. Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, эд хогшил болон тэдгээрийн хүлээн авалт, хадгалалт, зарцуулалтыг хариуцан ажиллаж байна.

Компанийн ажилтнуудыг бичиг хэргийн шаардлагатай хэрэгслэлээр хангах, цэвэр ус, цай, кофе, нэрийн хуудас, дугтуй, бусад материалаар тогтмол хангаж байна.

5.4. Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах талаар:

Компанийн цахим хуудсын өөрчлөлтөнд шилэн данс, бусад худалдан авалтын мэдээллийг шалган дутуу мэдээллийг байршууллаа.

2016 онд компанийн хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, ажлын төлөвлөгөөтэй холбоотой 15, хөрөнгө зарцуулахтай холбоотой 44, албан тушаалтан томилох, чөлөөлөхтэй холбоотой 14, бусад чиглэлээр 18, нийт 91 Гүйцэтгэх

захирлын тушаал батлагдан мөрдөгдөж байна. Мөн компаниас гарсан 231 албан бичгийг удирдлагууд хянаж, гарын үсэг зурсны дараа албан бланкан дээр бичиг хэргийн шаардлага, стандартын дагуу хэвлэн холбогдох байгууллага, газарт хүргүүлээ.

Удирдлагын өдөр тутмын ажиллах орчин нөхцөл, уулзалтын цагийн хуваарийг хөтлөн ажиллаж байна. Гаднаас ирсэн 143 албан бичгийг танилцуулах хуудсаар удирдлагад танилцуулж, хариуцах албан тушаалтнуудад хүргэж, хариуг нь гаргуулж ажилласан.

Гүйцэтгэх захирлын тушаал, ирсэн, явсан бичгийн бүртгэлийг цаасаар болон цахим хэлбэрээр хөтөлж байна. Мөн удирдлагуудад зориулсан албан бичгийн дундын сан, нийт ажилтнуудад зориулсан албан бичгийн дундын санг бий болгон холбогдох албан бичгүүдийг тавьж танилцуулж байна.

2016 оны 2 дугаар сард 2015 оны Санхүү, удирдлагын газрын баримт, худалдан авалтын материалуудыг 11 архивын нэгж болгон архивлаж дууссан. Банк, Даатгалын компани, Борлуулалтын хаалт, Гэрээнүүд гэсэн 4 хавтас нээж бичиг баримтаа архивласан. Мөн сурталчилгааны зурагт хуудас, цаг тооны бичиг, сонин зэрэг материалаас архивлаж байна. Даатгалын 8 компаниас 21 аймаг дахь салбаруудынх нь утасны жагсаалт, цахим шуудангийн хаягийг авч шинэчилсэн. Оффисын байрны эмх цэгц, зохион байгуулалтыг өдөр тутам хариуцан ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн анкетын бүрдлийг шинэчлэн цэгцлэв. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014, 2015, 2016 оны материалуудыг зохих журмын дагуу цэгцэлж, товъёог үйлдэн цахим хэлбэрээр хадгалсан ба эзэмшилд байгаа эд хөрөнгийн жагсаалт гаргаж, бүртгэл хийлээ.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн 2016 оны бизнес төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөөг батлах тухай, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн гүйцэтгэх захиралд их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэх тухай, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Япон улсад албан томилолтоор ажиллуулах тухай зэрэг Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын төслийг боловсруулж батлууллаа.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2016 оны 2 дугаар сарын 29-ний өдрөөс 3 дугаар сарын 4-ний өдрүүдэд Япон Улсын Токио хотноо тус улсын Санхүүгийн үйлчилгээний байгууллага, Хөдөө аж ахуйн яам болон даатгалын компаниудтай уулзах уулзалтыг зохион байгуулсан болно. Энэ ажлын хүрээнд компанийн зүгээс Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо, Япон Улсын Санхүүгийн үйлчилгээний байгууллага тус улсын Хөдөө аж ахуйн яаманд хүсэлт гарган уулзалтын цаг авах, тус улсад ажиллах зардлын төсөв боловсруулж, батлуулах, виз, онгоцны тийз, зочид буудал гэх мэт зохион байгуулалтын ажлыг хангах, уулзалтын ярианы сэдвийг боловсруулах, айлчлалын үеэр тавьсан компанийн танилцуулга, МИД-ын үйл ажиллагаа, Газар тариалангийн даатгалын тухай илтгэлүүдийг англи хэл дээр бэлтгэх зэргээр дэмжлэг үзүүлж ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод журам, компанийн дүрмийг шинэчлэн боловсруулах гэж байгаатай холбогдуулан компанийн тухай хууль, малын индексжүүлсэн даатгалын тухай хууль, төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод журам, компанийн дүрэм зэрэг хууль, дүрэм, журмын матрицыг боловсруулсан. Компанийн үйл ажиллагаатай холбоотой бүх дүрэм, журам, гэрээнүүдийн эх хувийг шийдвэрийн хамт нэгтгэсэн.

Гүйцэтгэх захирлын 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 04/16 дугаар тушаалаар батлагдсан ХАСХОМ гаргах албан тушаалтнуудын жагсаалтад заасан Төлөөлөн удирдах зөвлөлийн 6 гишүүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх захирлын орлогч, Газрын дарга, нягтлан бодогч зэрэг нийт 14 хүний 2015 оны ХАСХОМ-ийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хугацаанд нь гаргууллаа.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн 2016 оны авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Гүйцэтгэх захирлаар батлуулан Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, хэрэгжүүлж ажиллалаа. Албан тушаалтнуудын 2015 оны хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуй, албан тушаалтнуудын мэдүүлэг гаргасан талаарх тайлан, хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай бүртгэл зэргийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 02/33 дугаар тогтоолоор батлагдсан “Бизнес төлөвлөгөө-2016 он”, газар нэгжийн санал зэрэгт үндэслэн компанийн жилийн ажлын төлөвлөгөөг сарын хуваарьтайгаар боловсруулан Гүйцэтгэх захирлын 2016 оны 04/04 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хэрхэн гаргах талаар хичээл, танилцуулга бэлтгэн бүх ажилтнуудад хүргэн танилцууллаа. Энэхүү арга хэмжээний үр дүнд ажилтнуудын болон газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хугацаандаа гарган, чанартай бэлтгэн ирүүлж байна. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан, 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2016 оны үйл ажиллагааны тайлан, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн удирдлагад танилцуулав.

Газар, нэгж бүр дээр нэг ажилтны ажлын байрны тодорхойлолтонд газрын ажилтнуудын улирлын ажлын гүйцэтгэлийг хүлээн авах, газар, нэгжийн жил, улирлын ажлын тайлан, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн гаргаж газрын даргаар хянуулж, баталгаажуулах чиг үүргийг тусган ажилласан.

Мөн Гүйцэтгэх захирлын тушаалын биелэлт, шуурхай хуралдаанаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг холбогдох албан тушаалтнуудаас тодруулан биелэлтийг гаргуулан, хяналт тавьж ажиллалаа.

Компанид ажил үйлс бүтээж, эд хөрөнгийг аривжуулагч Баяннамсрай бурхныг аравнайлуулж, залав.

Байгууллагын дотоод, гадаад сүлжээний хэвийн ажиллагааг хангаж, гарсан доголдлыг цаг тухай бүрт нь арилгалаа. Мөн ажилтнуудын компьютерийн хэвийн үйл ажиллагааг хангаж, байгууллагын дотоод файлын сервер болон цахим сервер, өгөгдлийн сангийн серверийн хэвийн ажиллагааг хангаж ажиллалаа.

“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК
14210, Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энх тайваны өргөн чөлөө-23,
“UBH center”, 14 давхар, 1412 тоот
Э-шуудан: info@agreinsurance.mn
Вэб: www.agreinsurance.mn
Утас: 75770002
Факс: 75770003

Танилцсан:

Гүйцэтгэх захирал:

Г. Энхтайван

Гүйцэтгэх захирлын орлогч:

О.Наранхүү

Андеррайтингийн газрын дарга:

Т.Оюунбат

Бизнес хөгжил, төслийн газрын дарга:

Б.Батбаяр

Хөрөнгийн удирдлага, нөхөн
төлбөрийн газрын дарга:

Д.Дуулал

Нэгтгэсэн:

Санхүү, удирдлагын
газрын дарга:

Э.Ванчинхүү